

ЗАСГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР, ТҮҮНИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Аймгийн ЗДТГазар Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэх чиглэлээр дараахь ажлуудыг зохион байгуулсан байна.

1.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн үндсэн зорилтууд, тус аймагт холбогдох заалтуудыг аймгийн Засаг даргын болон нийт сумдын Засаг дарга нарын мөрийн хөтөлбөрт тусгаж, уялдуулах ажлыг 2008 оны 12 дугаар сараас 2009 оны 1-р сард багтааж хийсэн.

2.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх асуудлыг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэрэгжүүлэгч агентлаг, төсөвт албан байгууллагын жилийн болон хэтийн төлөвлөгөөнд тусгуулж, биелэлтийн байдалд сар улирлаар хяналт тавьж ажиллалаа.

3.Үйл ажиллагааны хөтөлбөр, төлөвлөгөөнд тусгагдсан томоохон зорилт арга хэмжээнүүдийг бүх шатны төрийн албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтонд суулган өгч биелэлт үр дүнг хагас, бүтэн жилээр хүн нэг бүрээр тооцож байна.

4.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх асуудлаар нийт сумдын ИТХ-ын дарга, Засаг дарга, хэрэгжүүлэгч агентлаг, хэлтэс албадын дарга нарын 2 өдрийн сургалт семинарыг Өлгий хотод зохион байгуулсны дээр энэ сэдвээр Засгийн газраас зохион байгуулсан бүсчилсэн болон төвлөрсөн сургалтанд нийт сумдын удирдлага, холбогдох ажилтнуудыг оролцуулсан болно.

5.Үйл ажиллагааны хөтөлбөр, төлөвлөгөөнд тусгагдсан тус аймагт холбогдолтой зорилт арга хэмжээ нэг бүрийг орон нутагт зохион байгуулж хэрэгжүүлэх дэлгэрэнгүй төлөвлөгөө гаргаж, түүнийг эрхлэх асуудлынх нь чиг үүргийн дагуу тодорхой байгууллага, албан тушаалтанд хариуцуулан биелэлтэнд нь хяналт тавьж ажиллалаа.

6. 2009 онд аймгийн ЗДТГ нь Засгийн үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан тус аймагт холбогдолтой 97 зорилт, 174 арга хэмжээг хяналтанд авч ажилласнаас нийт дүнгээр 27,6 хувийг нь хэрэгжүүлсэн байна.

Аймгийн ЗДТГазар 2009 онд Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг биелүүлэх ажлын хүрээнд дараахь томоохон ажлуудыг зохион байгуулсан байна.

Үүнд:

1.Өнгөрсөн онд Өлгий-Цагааннуур-Ногооннуур сумыг холбосон 35 кВт-ын өндөр хүчдлийн шугамыг хүлээн авснаар тус аймгийн Булганаас бусад бүх сум баруун бүсийн эрчим хүчний системд холбогдсон. Булган сумыг Ховд аймгийн Дуутаас өндөр хүчдэлд холбохоор ажлыг нь эхлүүлсэн, 2010 оны эхний хагасад ашиглалтад орно.

2. 2008, 2009 онд Зам гүүр, барилгын салбарт 2,76 тэрбум төгрөгийн ажил хийгдэж Сагсайн голын гүүрийн ажлыг дуусгаж, Улаанхус сум дахь Ховдын голын томоохон бетон гүүрийг 2010 онд ашиглалтад авах боломжтой болжээ.

3. Өлгий хотын Нисэх буудлын 11,7 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй хатуу хучилттай зурвас, 1,7 тэрбум төгрөгийн өртөгтэй Спорт цогцолборын барилгын ажил идэвхтэй хийгдэж онгоцны буудлын зурвас 2011 онд, Спортын цогцолбор 2010 онд ашиглалтад орох боломжтой болсон.

4.2009 онд үйлдвэрлэлийг дэмжих жилийн ажлын хүрээнд улсын төсвөөс олгосон 763,0 сая төгрөгийн хөнгөлөлтэй зээлийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн болон барилгын материалын үйлдвэр, ахуйн болон худалдаа үйлчилгээ гэсэн 8 үндсэн чиглэлээр 83 аж ахуйн нэгжид олгосноор 361 ажлын байртай болсон.

5.2009 оны байдлаар тус аймагт 70 шахам мал эмнэлэг, үржлийн албаны нэгж ажиллаж байгаа. Энэ онд мал сүргийг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 241,0 сая төгрөгийг улсын төсвөөс олгож, шаардагдах эм тарилгаар хангасан. Ямар нэгэн гоц халдварт өвчин гараагүй. Өнгөрсөн онд аймгийн хэмжээнд Сагсай, Бугат, Булган, Улаанхус, Цэнгэл зэрэг сумдад нийт 830 га-гийн услалтын системийг сэргээн засварласан, 3500 тн төмс, 1100 тн хүнсний ногоо хураан авч, аймгийн хэрэгцээт төмсний 60%, хүнсний ногооны 17%-ийг өөрийн үйлдвэрлэлээр хангах боломжтой болжээ.

6.Өнгөрсөн онд аймгийн эрүүл мэндийн байгууллагын материаллаг баазыг бэхжүүлэх, эмч мэргэжилтнүүдийн чадавхийг дээшлүүлэхэд чиглэсэн зарим тодорхой ажлуудыг хийсэн байна. Тухайлбал, аймгийн нэгдсэн эмнэлэгт туулах чадвар сайтай 3 автомашин, 200,0 орчим сая төгрөгийн эмчилгээ оношлогооны тоног төхөөрөмж нийлүүлсэн. Дэлүүн, Цэнгэл, Булган, Алтай, Буянт сумдыг “Тогтвортой амьжиргаа-II” төслийн 150,0 сая төгрөгийн санхүүжилтээр ЭХО аппарат болон зарим чухал шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангажээ. 2009 онд төвлөрсөн болон бүсчилсэн 6 удаагийн сургалтанд 150 эмч, мэргэжилтнийг хамруулсан нь тэдний чадавхийг дээшлүүлэхэд үр дүнтэй болжээ.

Эдгээр ажлын үр дүнд 1-5 насны хүүхдийн эндэгдэл, сүрьеэ зэрэг халдварт өвчин буурсан сайн үзүүлэлт гарсан боловч эхийн болон 0-1 насны хүүхдийн эндэгдэл нэмэгдсэн нь анхаарал татаж байна.

7.Аймгийн хэмжээнд 2009 онд боловсролын салбарт нийт дүнгээр 1,0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулж Цэнгэл, Дэлүүн сумдын ахлах сургуулиудын дотуур байранд их засвар, Алтай, Сагсай сумын ахлах сургуулийн өргөтгөл хийж, Баяннуур, Сагсай, Цэнгэл сумын сургуулийн дотуур байрны үйлчилгээг сайжруулах арга хэмжээ авсан.

Мөн Өлгий хот дахь Багшийн коллежийн хичээлийн байранд 200,0 сая төгрөгийн их засвар хийж, 300,0 сая төгрөгийн сургалтын тоног төхөөрөмж нийлүүлсний дээр МСҮТ-ийн менежментийг шинэчилж, дотуур байрыг засварласан. Эдгээр ажлын үр дүнд боловсролын салбарын үйл ажиллагаа бүхэлдээ хэвийн явагдах нөхцөл боломжтой болсон байна.

8.Тус аймгийн Хөдөлмөр, нийгмийн халамжийн үйлчилгээний ажил ахицтай байна. 2009 онд иргэдэд 9,3 тэрбум төгрөгийн халамжийн үйлчилгээ үзүүлсэн нь 2008 оныхоос 1,0 тэрбум төгрөгөөр илүү байна. Аймгийн хэмжээнд 2008, 2009 онд 2969 хүн байнгын 1215 хүн түр ажлын байраар хангагдсан байна.


9.Тус аймаг орон нутгийн төсвийн орлогын бааз суурийг өргөжүүлэх, төсвийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах, хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлэхэд анхаарч үр дүнд хүрсэн байна. 2009 оны төвлөрсөн төсвийн орлогын төлөвлөгөөг 220.0 сая төгрөгөөр буюу 45 хувиар, орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг 658,0 сая төгрөгөөр буюу 32,3%-иар давуулан биелүүлсэн байна.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг биелүүлэх ажил зохих түвшинд хийгдэж үр дүнд хүрч байгаа боловч хэрэгжилт нь удааширч байгаа болон тасалдаж байгаа ажлууд цөөнгүй байгааг цаашид анхаарч ажиллах болно.

Засгийн газрын болон аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрөөс хэрэгжилт нь удааширч байгаа болон тасалдаж байгаа заалтуудын биелэлтийг хавсаргав.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭНИЙ ТАСАГ

Үндэсний аюулгүй байдал, гадаад бодлогын зорилт



Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

НЭГ. ХҮН АМ НИЙГМИЙН ЗОХИСТОЙ БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛСНЭЭР ИРГЭДИЙН АМЬДРАЛЫН ЧАНАРЫГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТ

1.1. Эрүүл мэндийн бодлого

1.1.1.1. Нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлого, үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөлт, санхүүжилтийн механизмыг төв болон орон нутгийн түвшинд оновчтой болгоно.

Биелэлт: 2009 онд аймгийн эрүүл мэндийн байгууллагын материаллаг баазыг бэхжүүлэх, эмч мэргэжилтнүүдийн чадавхийг дээшлүүлэхэд чиглэсэн зарим тодорхой ажлуудыг хийсэн. Тухайлбал, аймгийн нэгдсэн эмнэлэгт туулах чадвар сайтай 3 автомашин, 200,0 орчим сая төгрөгийн эмчилгээ оношлогооны тоног төхөөрөмж нийлүүлсэн. Дэлүүн, Цэнгэл, Булган, Алтай, Буянт сумдыг “Тогтвортой амьжиргаа-II” төслийн 150,0 сая төгрөгийн санхүүжилтээр ЭХО аппарат болон зарим чухал шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангасан. 2009 онд төвлөрсөн болон бүсчилсэн 6 удаагийн сургалтанд 150 эмч, мэргэжилтнийг хамруулсан нь тэдний чадавхийг дээшлүүлэхэд үр дүнтэй болсон. Аймгийн хүн амын өвчлөлтийн судалгааг жил тутам нарийвчлан гаргаж, өвчлөл эндэгдлийг бууруулахын тулд хүн амын дунд төлөвлөгөөт нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгийг зохион байгуулахын хажуугаар, эрүүл аж төрөх ёс зөв хоололт, эрүүл мэндээ хамгаалах, хорт зуршил, буруу дадал хэвшлээс ангижрах талаар сургалт, сурталчилгааг тухай бүр хийж, зарим сумдад цус багадалт, гаж хөгжлийн судалгааг олон улсын байгууллагын дэмжлэгээр хийж байна.

Хэрэгжих шатандаа-50%

1.1.1.3. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын удирдамжийн дагуу эрүүл хот, дүүрэг, сум, баг бий болгох үндэсний хэмжээний хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.

Хөтөлбөр батлагдаагүй-0

1.1.4.1. Төлбөрийн чадваргүй, амьжиргааны доод түвшингээс доогуур орлоготой иргэдэд төрөлжсөн нарийн мэргэжлийн эмнэлгийн тусламжийг үнэ төлбөргүй авах эрхийн бичиг олгох үр дүнтэй механизмыг судалж шийдвэрлэнэ.

Биелэлт: Төлбөрийн чадваргүй, амьжиргааны баталгаат түвшингээс доогуур орлоготой иргэдэд төрөлжсөн мэргэжлийн тусламжийг үнэ төлбөргүй үзүүлэх нөхцлийг бүрдүүлэн, зөвлөгөө өгөх, хэвтүүлэн эмчлүүлэхэд шаардлагатай бичиг баримтыг гаргаж өгч ажиллаж байна. Эрхийн бичгийн асуудал одоогоор шийдэгдээгүй байгаа.

Хэрэгжих шатандаа-0%

1.1.5.1. Эрүүл мэндийн салбарын эрх зүй, санхүүгийн зохицуулалтын механизмыг боловсронгуй болгоно.

Биелэлт-Эрүүл мэндийн салбарын эрх зүй, санхүүгийн зохицуулалтын механизмыг боловсронгуй болгох талаар санал боловсруулж Эрүүл мэндийн яаманд хүргүүлсэн. Цаашид энэ заалтыг аймгийн ЗДТГ-ын хяналтаас хасах саналтай байна.

Хэрэгжилт-0

1.1.5.2. Эрүүл мэндийн салбарын төрийн байгууллага болон хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх бодлого боловсруулж, хэрэгжүүлэх оновчтой механизмыг бүрдүүлнэ.

Биелэлт: Аймгийн хэмжээнд 2009 онд хувийн хэвшлийн шинээр зургаан эмнэлгийн эрхийг нь олгож, тэдний үйл ажиллагаанд мэргэжлийн хяналт тавихын зэрэгцээ татвар, зээл, санхүүгийн хувьд бүх талын дэмжлэг үзүүлж байна.

Хэрэгжих шатандаа-90%

1.1.6.3. Бүх шатны эрүүл мэндийн байгууллагын (төрөлжсөн мэргэжлийн, аймаг, дүүрэг, сумын болон өрхийн эмнэлгийн) үйл ажиллагааны стандартыг шинэчилнэ.

Биелэлт: Сумын эмнэлгийн бүтэц үйл ажиллагааны стандарт MNS 5082:2001 болон өрхийн эмнэлгийн MNS 5292:2003 стандартуудын талаар сум, өрхийн эрхлэгч нарын саналыг авч ЭМЯаманд явуулсан. Эрүүл мэндийн байгууллагын шинэ стандарт батлагдаагүй байгаа.

Хэрэгжих шатандаа-30%

1.1.7.5. Аймаг бүрт 5-6 сумын дунд явуулын амбулаторийн үйлчилгээг бий болгож, тоноглогдсон тээврийн хэрэгслээр хангана.

Биелэлт: НҮБ-ын хүн амын сангаас “Нөхөн үржэхүйн эрүүл мэнд” үндэсний хөтөлбөрийн зорилтуудыг хэрэгжүүлэх зорилгоор Малчдын явуулын амбулаторын үйлчилгээ үзүүлэх шугамаар 2009 оны 10 сард иж бүрэн тоноглогдсон фургон автомашин болон Дэлхийн зөн байгууллагын орон нутгийн хөгжлийн хөтөлбөрүүдийн санхүүжилтээр эмнэлгийн түргэн тусламжийн зориулалтын Тоёото Ланд-Круйзер автомашин тус тус олгогдон жилд 1-2 удаа нийт сумуудад нарийн мэргэжлийн үзлэг эмчилгээ хийн, зөвөлгөөг өгч, хөдөөгийн хүн амын дунд мэдээлэл, сургалт сурталчилгаа явуулж байна.

Хэрэгжих шатандаа-30%

1.1.7.6. Өрх, сумын эмнэлэг бүрийг нэн шаардлагатай тусламж үйлчилгээний багцад заасан эмнэлгийн тусламж, үйлчилгээг хүн амд, бүрэн үзүүлэх чадавхитай болгох, өвчнөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг нь түлхүү хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

Биелэлт: 2009 оны 6-р сарын 9-ний өдөр аймгийн Нэгдсэн эмнэлэгт тарваган тахлын булчирхайн хэлбэрийн сэжигтэй өвчтөн хэвтсэн тухай мэдээллээр аймгийн онцгой комисс хуралдаж, Нэгдсэн эмнэлэг болон өвчний голомтот газар болох Сагсай сум, аймгийн бусад сумдын чиглэлд хорио цээрийн дэглэм тогтоож, анхан шатны арга хэмжээг авч, улмаар БГХӨСҮТөөс мэргэжлийн баг ирж тарваган тахлын голомтод ажилласанаар энэхүү онц халдварт өвчний тархалтаас хамгаалж чадсан юм. Улс орон даяр тархсан А хүрээний H1N1 вирусын томуу өвчин гарсантай холбогдуулан аймгийн Онцгой комисс тухайн сард 7 удаа хуралдаж, зарим шуурхай арга хэмжээний талаар Засаг даргын захирамж гарган хэрэгжүүллээ. Манай аймагт 5 хүн томуугийн H1N1 вирусын халдвар авсан нь шинжилгээгээр батлагдсан ба эрүүл мэндийн тусламж үйлчилгээний ачаар өвчтөнүүдийн биеийн байдал сайжирсан. Өндөржүүлсэн бэлэн байдал зарласантай холбоотой ЕБС-иудын хичээлийг орон нутгийн радио телевизээр казах хэлээр заах арга хэмжээ авагдлаа. Энэ талаар аймгийн Засаг дарга БСШУЯ-ны сайдаас албан ёсоор зөвшөөрөл авч, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулсан юм.

Хэрэгжих шатандаа-70%

1.1.7.7. Сумын эмнэлгийн ариун цэвэр, эрүүл ахуйн стандартыг боловсруулан мөрдүүлж, нөхцлийг сайжруулна.

Хэрэгжээгүй - 0%

1.1.7.8. Багийн хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд багийн бага эмчийг бэлтгэж, унаатай болгоно.

Биелэлт: “Тогтвортой амжиргаа-2” төслийн шугамаар Ногооннуур сумын 1 болон 8 дугаар баг, Алтай сумын 3 дугаар багийн эмч нарыг унаатай /мотоциклтэй/ болгосон. Одоогоор 10 багийн эмч мотоциклтэй, 4 баг автомашинтай, бусад 63 багийн бага эмч морьтой байна.

Хэрэгжих шатандаа-30%

1.1.9.1. Шинэ болон дахин сэргэж буй халдварт өвчнийг лабораторийн шинжилгээнд үндэслэн тандах тогтолцоог үндэсний түвшинд бэхжүүлэх арга хэмжээ авна.

Биелэлт: Аймгийн нэгдсэн эмнэлгийн лабораторийн тоног төхөөрөмжийг шинэчлэх, эмч мэргэжилтнүүдийг чадваржуулах хэтийн төлөвлөгөө боловсруулаад байна.

Хэрэгжих шатандаа-10%

1.1.9.4. "Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх үндэсний хөтөлбөр"-ийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, шинэчлэн боловсруулна.

Биелэлт-Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд дараах ажлуудыг зохион байгууллаа. Аймгийн хэмжээнд БЗХӨ илрүүлэх үзлэгийн хуваарь гарган 8 суманд нарийн мэргэжлийн эмч нарын хамтарсан үзлэг хийж, сум бүрт БЗХӨ-ний талаар МСС хийж БЗХӨ-ний эмийг үнэ төлбөргүй тараасан. Бүх сумдад Гахайн томуугийн А хүрээний Н1N1 шинэ вирусын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар зөвлөгөө өгч, яриа хийж, зөвлөмж тараасан. УЗХороотой хамтран 24 хүнийг БЗХӨ-өөс сэргийлэх, зөвлөгөө өгөх чадвартай болгон сургагч багшаар бэлтгэсэн. Аймгийн FM радиогоор асуулт хариултын тэмцээн зохион байгуулсан. Булган, Дэлүүн, Толбо сумуудын зочид буудлын эзэд, коллежийн оюутануудад 100 хувь “бэлгэвч хөтөлбөрийг хэрэгжүүлэх тухай” ажлын байрны сургалт зохион байгуулсан. Нийт 308 хүнийг сүрьеэ өвчний шинжилгээнд хамруулан, эерэг илэрсэн 6 хүнийг хяналтанд авсан. ХӨСҮТ-ээс 2 удаа хэрэгцээт вакциныг захиалан авч нэгж байгууллагуудын захиалга хэрэгцээг үндэслэн нийлүүлж байна. 4 өрхийн эмнэлэг, Дэлүүн, Толбо, Улаанхус, Баяннуур, Алтанцөгц сумын дархлаажуулалтын байдалд хяналт тавьж зөвлөмж өгсөн. Нэгдсэн эмнэлгийн вакцины хадгалалт, хамгаалалтын байдалд 3 удаа хяналт тавьж зөвлөмж заавраар хангасан. Гэдэсний халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх ажлыг эрчимжүүлэх талаар Аймгийн засаг даргын захирамж гарч, бүх сумын удирдлага нарт танилцуулан төлөвлөгөөний дагуу ажилласан. Халдварт өвчний талаар орон нутгийн радиогоор мэдээлэл өгч томуу, томуу төст өвчин, халдварт шар өвчин, А хүрээний Н1N1 шинэ вирусын халдварын талаар сурталчилсан. "Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх үндэсний хөтөлбөр шинэчилж батлагдаагүй байгаа.

Хэрэгжих шатандаа-90%

1.1.11.2. Алсын зайн оношлогооны сүлжээг өргөжүүлж, бүх аймгийн нэгдсэн эмнэлгийг хамруулна.

Биелэлт: Аймгийн Нэгдсэн эмнэлгийг ЭНЭШТ, Улсын Клиникийн III эмнэлэгтэй алсын зайн оношлогооны сүлжээнд холбох үйл ажиллагааг Засгийн газар, Эрүүл Мэндийн Яам, бусад холбогдох байгууллагуудад удаа дараа уламжилан хөөцөлдөж байна. Аймгийн зүгээс алсын зайны оношлогоонд холбох бэлтгэл ажлуудыг хийгээд байна. Аймгийн Засаг даргын нөөц сангаас 6,0 сая төгрөгөөр 10 компьютер нийлүүлсэн болно.

Хэрэгжих шатандаа-50%

1.1.13.2. Аймгийн НЭ-ийн дэргэдэх төрөх, хүүхдийн тасгийн тоног төхөөрмжийг сайжруулж, хэрэгцээг харгалзан шаардлагатай тохиолдолд төрөх газар болон хүүхдийн эмнэлгийг шинээр барьж, перинатологийн төв байгуулна.

Биелэлт - Эх хүүхдийн өвчлөл, эндэгдлийг багасгах зорилгоор УБ хотоос ЭНЭШТөвийн сэхээн амьдруулах яаралтай тусламжийн өндөр нарийн мэргэжлийн 2 эмчийг урьж аймаг, сум, өрх, НЭ-ийн төрөх тасгийн эмч нарт 5 хоногийн сургалт, сумын эмч нарт 3 хоногийн ЭХО-гийн сургалт хийж, эх баригч нарыг Говь-Алтай аймгийн АУ-ны коллежид сургалтанд хамруулав. Сумдын багийн эмч нарыг бүсчилсэн сургалт семинарт хамруулсан. Гэвч эхийн эндэгдэл 6 болж нэмэгдсэн, мөн 0-1 насны хүүхдийн эндэгдэл 2008 онд 41, 2009 онд 48 болж нэмэгдсэн байна. Харин 1-5 насны хүүхдийн эндэгдэл болон сүрьеэ өвчнөөс шалтгаалсан нас баралт өмнөх оныхоос буурсан үзүүлэлттэй байна.

Хэрэгжих шатандаа-10%

1.1.19.1. "Биеийн тамир спортын талаар төрөөс баримтлах бодлого"-ыг боловсруулж, биеийн тамир, спортын эрчимтэй хөгжлийг хангах эрх зүйн удирдлага зохион байгуулалт, санхүүжилтийн эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.

Биелэлт – 2009-2012 онд хөгжүүлэх спортын төрлүүдийг сонгож стратеги төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлж ажиллаж байна. Засаг даргын дэргэд өсвөрийн шигшээ баг байгуулах спортын төрлүүдийг сонгож, баг тамирчдыг сонгон шалгаруулж, төсөв хөрөнгийг нь шийдвэрлүүлэхээр бэлэн болгосон. Засгийн газрын 05 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд тодорхой ажлуудыг хийж холбогдох газруудад тайлан мэдээг хүргүүлж байна.

Хэрэгжих шатандаа-30%

1.1.19.2. Биеийн тамир спортоор хичээллэхийн ач холбогдлыг сурталчлах мэдээлэл, сурталчилгааны ажлыг нэгдсэн байдлаар зохион байгуулна.

Биелэлт-БТСпортоор хичээллэх, бие бялдрын сорилын ач холбогдол, ард иргэдийг нийтийн биеийн тамир спортод татан оролцуулах талаар тусгайлан сэдэв боловсруулан, хөдөлгөөний хомсдлоос урьдчилан сэргийлэх, ажлын байранд хийх дасгал хөдөлгөөний талаар албан байгууллага, аж ахуйн нэгжид сурталчлан тусгай тэмцээн зохион байгуулж, радио телевизээр сурталчилсан.

Хэрэгжих шатандаа-30%

1.1.19.3. Нийтийн биеийн тамир спортын байгууллагын барилга байгууламжийн засвар үйлчилгээ, ашиглалтыг үе шаттай сайжруулна.

Биелэлт-Өлгий хотын төвд баригдаж байгаа Биеийн тамир спортын цогцолбор барилгын хөрөнгө оруулалт бүрэн хийгдсэн ба барилгын ажил хэвийн явагдаж байна. Спорт цогцолборын барилгын ажил 70%-тай хийгдсэн, уг барилгын ажлыг 6-р сард дуусгаж аймаг байгуулагдсны 70 жилийн ойн өмнө ашиглалтад оруулна.

Хэрэгжих шатандаа-50%

1.1.20.3. Хяналт-шинжилгээ, судалгааны үр дүн, нотолгоог ХДХВ/ДОХ/БЗДХ-ын эсрэг хариу арга хэмжээ төлөвлөх, шийдвэр гаргахад үр дүнтэй ашиглана.

Биелэлт- Энэ чиглэлээр Дэлүүн сумын эмнэлгийн үйл ажиллагаанд хяналт шинжилгээ үнэлгээ хийж, төлөвлөгөө боловсруулсан.

Хэрэгжих шатандаа-30%

1.2. Боловсрол, соёл, шинжлэх ухааны бодлого

1.2.2.1. Баг бүрт гэр цэцэрлэг байгуулж, хувийн хэвшлийн цэцэрлэг байгуулахыг дэмжин сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтыг нэмэгдүүлнэ.

Биелэлт- 2009-2010 оны хичээлийн жилд цэцэрлэгийн өдрийн бүлэгт 3628 хүүхэд, хувилбарт сургалтанд 2057 хүүхэд буюу СӨБ-д 5685 хүүхэд хамрагдаж, хамран сургалт 68,8%-д хүрсэн. Энэ нь өмнөхөөс 2,6%-иар нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Хэрэгжих шатандаа-50%

1.2.2.2. Хүүхдийн цэцэрлэгийн хоолны зардлын номативыг шинэчлэн баталсан ёсоор цэцэрлэгийн нэг хүүхдийн хоолны нэг өдрийн зардлын хэмжээг 1100 төгрөгөөр өмчийн хэлбэрийг үл харгалзан олгож байна.

Хэрэгжих шатандаа – 50%

1.2.2.4. Цэцэрлэгийн тоглоом наадгай, тоног төхөөрөмжөөр хангаж, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлнэ.

Биелэлт – 2009 онд Дэлхийн Зөн ОУ-ын байгууллагын төслийн санхүүжилтээр 4 цэцэрлэгт тоглоом наадгай, тоног төхөөрөмж ологодсон.

Хэрэгжих шатандаа-30%

1.2.2.5. Цэцэрлэгийн барилга барих, өргөтгөх, засварлах замаар хүчин чадлыг нэмэгдүүлнэ.

Биелэлт – Өлгий сумын 3,5 дугаар багт 2 цэцэрлэг шинээр, Алтай сумын 1-р багт 1 бүлэг, Ногооннуур сумын төвд 1 бүлэг, Хотгор багт 1 бүлэг, Цагааннуур тосгоны цэцэрлэгт 2 бүлэг, Улаанхус сумын Хөхэрэгт 1 бүлэг, Алтанцөгц суманд, 1 бүлэг тус тус нэмж байгуулан ажиллаж байна.

Хэрэгжих шатандаа-50%

1.2.3.5. Бага боловсролын хамран сургалтыг 95,0 хувьд хүргэнэ.

Биелэлт – Ерөнхий боловсролыг 12 жилийн тогтолцоонд шилжүүлж эхэлсэнтэй холбогдуулан 1,2- анги болон шилжилтийн 7-р ангиуд 12 жилийн тогтолцооны хөтөлбөрөөр хичээллэж байна. Эдгээрт шаардагдах сурах бичгийн /казах 1,2-р анги/ асуудал шийдэгдсэн.

2008 онд 6 настай хүүхдийн сургуульд хамралтын байдал 57% байсан бол 2009 онд 66%-тай болж нэмэгдсэн байна.

Хэрэгжих шатандаа-30%

1.2.4.5. Багшийн мэргэжил, үнэлэмж, нэр хүндийг дээшлүүлж, багш, боловсролын байгууллагын удирдах ажилтны цалин, хангамжийг нэмэгдүүлнэ.

Биелэлт – Мэргэжлийн багшийн хангалтыг 2009-2010 оны хичээлийн жилд 99,8%-д хүргэх зорилт дэвшүүлээд 99,3%-ийн биелэлттэй байна. Аймгийн хэмжээнд ажил идэвхтэй хайж байгаа 680 орчим багш байгаа. Хичээлийн жилийн эхэнд ажилгүй байгаа багш нарын нэгдсэн сонгон шалгаруулалтыг анх удаа зохион байгуулж, авсан оноо, эзэлсэн байрны дараалалаар нь ажлын байраар хангах бодлого хэрэгжүүлэн ажиллаж байна. Шинэ хичээлийн жилд 56 багш бүр болон түр ажлын байраар хангагдсан. Багш нарын үр дүнгийн урамшууллыг 10-15 хувиар тооцон улирал бүр олгож байгаа. 2009 оны байдлаар эдийн засгийн хямрлын байдлаас болоод цалин хөлс нэмэгдээгүй.

Хэрэгжих шатандаа-30%

1.2.4.6. Багш, ажилтнууд сургууль дээрээ мэргэшил дээшлүүлэх, бүтээлчээр ажиллах нөхцөл бүрдүүлэхэд шаардлагатай орчны стандарт боловсруулж, төрийн өмчийн бүх сургуулийн багш нарын өрөө, ажлын байрыг стандартын шаардлагын дагуу тоноглоно.

Биелэлт – Аймгийн хэмжээн дэх бүх ахлах сургуулиудад багш нарыг хөгжүүлэх танхим байгуулагдан, үйл ажиллагаагаа стандартын дагуу явуулж байна.

Хэрэгжих шатандаа-70%

1.2.5.1. Хүн амын бичиг үсэг тайлагдалтын түвшинг нэмэгдүүлнэ.

Биелэлт- Бичиг үсгийн сургалтыг бүх сумдын гэгээрлийн төвд явуулж, БСГ-ын дэргэд 1 бүлэг холимог хэлбэрээр хичээллэж байна. Бичиг үсэг тайлагдалтын түвшин өмнөх оныхоос 0,6%-р нэмэгдсэн байна.

Хэрэгжих шатандаа-30%

1.2.5.2. ЕБС-с завсардсан сурагчдад албан бус боловсрол, дүйцсэн хөтөлбөрийн сургалтаар боловсрол нөхөн олгоно.

Биелэлт- Сургууль завсардсан хүүхдүүдийг албан бус боловсрол олгох сургалтад хамруулан зохих шатны боловсролыг нөхөн олгож байна. Казах хүүхдийн боловсролыг дэмжих үндэсний хөтөлбөрийг төлөвлөгөөтэй хэрэгжүүлж байна. Дэд хөтөлбөр боловсруулагдаж, улсын төсвөөс 37 сая төгрөгний хөрөнгө оруулалт хийгдэж, уг хөтөлбөр нь амжилттай хэрэгжиж байна. Албан бус боловсролын орон тооны асуудлыг шийдэн, хөдөөгийн 12 сумын сургуульд албан бус боловсролын багш ажиллаж 630 орчим хүүхдийг дүйцсэн хөтөлбөрөөр хичээллүүлэн нөхөн боловсрол олгох, зуны зайны сургалт зохион байгуулах ажлууд хийгдсэн боловч сургууль завсардалт буураагүй үзүүлэлттэй байна. Одоогоор сургуульд хамрагдаагүй байгаа 855 хүүхдийн 3% орчим нь 6-14 насны хүүхдүүд байна.

Хэрэгжих шатандаа-50%

1.2.6.3. Төрөөс ЕБС-ийн сурагчдыг сурах бичгээр хангах график төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг зохион байгуулна.

Биелэлт- 2009-2010 оны хичээлийн жилд 25 нэр төрлийн сурах бичиг шинэчлэгдсний дотор 12 жилийн бүтцийн 1,2-р ангийн казах сурах бичгүүд 100% хангагдав. Бусад ангиудын хувьд 38%-тай байна.

Хэрэгжих шатандаа-30%

1.2.7.1. Үдийн хоол хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан сургуулийн хоолны газар, дотуур байрны гал тогоог зориулалтын тоног төхөөрөмжөөр хангах ажлыг зохион байгуулна.

Биелэлт- “Үдийн цай” хөтөлбөрт 2009-2010 оны хичээлийн жилд 13217 хүүхэд хамрагдаж, улсын төсвөөс 923,520,0 сая төгрөг төлөвлөгдсөн. Зарцуулалтын хяналтыг сайжруулах үндсэн дээр 120,0 сая орчим төгрөгийг хэмнэж, хүрэлцэхгүй байгаа бусад эх үүсвэрийг санхүүжүүлж байна.

Хэрэгжих шатандаа-90%

1.2.7.2. "Үдийн хоол" хөтөлбөрийг хэрэгжүүлэх журам батлан мөрдүүлж, сурагчдыг хөтөлбөрт ээлж дараатай хамруулна.

хэрэгжилт-0%

1.2.9.1. Ерөнхий боловсролын сургуулийн 3 дугаар ээлжгүй болгоход чиглэсэн арга хэмжээ авна.

Биелэлт- Улсын төсвөөс 40,0 сая, орон нутгийн төсвөөс 29,0 сая төгрөгийн хөрөнгө гаргаж аймгийн төвд 224 хүүхдийн багтаамжтай иж бүрэн 2-р бага сургуулийг шинээр барьж ашиглалтанд оруулав. Ерөнхий боловсролын сургуулийн 3 дугаар ээлжгүй болгоход чиглэсэн арга хэмжээ авч байгаа боловч тодорхой үр дүн гараагүй, хотын төвийн сургуулиуд ачаалалттай ажиллаж байна.

Хэрэгжих шатандаа-30%

1.2.9.3. Ангийн самбар, тавилга, сурагч, багшийн ширээ, сандлыг ээлж дараатай шинэчилнэ.

Биелэлт- Алтай, Сагсай сумдын ахлах сургуулиудыг төсөл, хөтөлбөрийн шугамаар 120 ширээ сандал, 2-р бага сургуульд 100 хүүхдийн ширээ сандлыг төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн. Мөн Буянт, Улаанхус, Толбо, Ногооннуур сумдын сургуулиудыг 380 хүүхдийн ширээ сандалаар хангасан болно.

Хэрэгжих шатандаа-30%

1.2.9.4. Дотуур байр барьж, өргөтгөн, дотуур байрны орчин, ариун цэвэр, усны хангамжийг сайжруулна.

Биелэлт- Аймгийн хэмжээнд 2009 онд боловсролын салбарт нийт дүнгээр 1,0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулж Цэнгэл, Дэлүүн сумдын ахлах сургуулиудын дотуур байранд их засвар, Алтай, Сагсай сумын ахлах сургуулийн өргөтгөл хийж, Баяннуур, Сагсай, Цэнгэл сумын сургуулийн дотуур байрны үйлчилгээг сайжруулах арга хэмжээ авсан. Улаанхус сумын Хөх-хөтөл багт дотуур байрны зураг төсөв хийгдэж, хэрэгжих шатандаа байна.

Хэрэгжих шатандаа – 50%

1.2.10.1. Зарим аймгийн төвд усан бассейн байгуулж хүүхэд, залуучуудын биеийн тамир, спортоор хичээллэх орчин бүрдүүлнэ.

Хэрэгжээгүй байгаа-0

1.2.12.2. Хөдөлмөрийн зах зээлийн судалгааг сайжруулж, эрэлт, нийлүүлэлтэд тохирсон мэргэжилтэй ажилтан бэлтгэх төлөвлөлтийг сайжруулна.

Биелэлт-МСҮТ-ийн сургалтын дадлагын байрны техник хэрэгслийн хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор жил бүр хөдөлмөрийн зах зээлийн хөдөлмөрийн багтаамж, хэрэгцээ, ажил олгогч нарын захиалгыг үндэслэн гагнуурчин, цахилгаанчин, мужаан, тогооч, экскаваторчин, засал, чимэглэл зэрэг 16 мэргэжлээр суралт явуулдаг. Дадлагын байр шинээр 4 нэмж байгуулсан. Багш нарын компьютерийн лабораторын кабинет нээж, 20 компьютер нэмж нийлүүлэв. Хуучин байранд 90,0 сая төгрөгийн их засвар хийж, сургалтын орчинг бүрэн шинэчлэв. Сургалтын орчин сайжруулах зорилгоор МСҮТ-ийг орон нутгийн 19,8 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар бохирын нэгдсэн шугамд холбосон. МСҮТ-д элсэх хүүхдийн тоо өмнөх жилийнхээс 30%-р нэмэгдсэн.

Хэрэгжих шатандаа-70%

1.2.14.3. Дотоодын их, дээд боловсролын сургуульд суралцахаар зохих журмын дагуу элсэж, сумын ИТХ-ын Тэргүүлэгчид, Засаг даргын захиалгаар албан ёсны гэрээ байгуулсан оюутны сургалтын зардлыг төрөөс хариуцна.

Хэрэгжилт-0%

1.2.20.1. Бүсийн төвүүдэд үйл ажиллагаа явуулж байгаа дээд болон мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагыг төрөөс дэмжинэ.

Биелэлт- Өлгий хот дахь багшийн Коллежийн хичээлийн байранд 200,0 сая төгрөгийн их засвар хийж, 300,0 сая төгрөгийн сургалтын тоног төхөөрөмж нийлүүлсний дээр МСҮТ-ийн менежментийг шинэчилж, дотуур байрыг засварласан. Эдгээр ажлын үр дүнд мэргэжлийн боловсролын салбарын үйл ажиллагаа бүхэлдээ хэвийн явагдах нөхцөл боломжтой болсон байна.

Хэрэгжих шатандаа-30%

1.2.25.1. Соёлын төвүүдийн барилгыг шинээр барих, их засвар хийх ажлыг дэс дараатай хэрэгжүүлнэ.

Биелэлт-Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн хурлаар ХДТеатрыг хөгжүүлэх дэд хөтөлбөр батлуулсан. Аймгийн ХДТ-ын ширээ сандлыг шинэчлэх асуудлыг аймгийн удирдлагууд гол асуудал болгон анхаарч ажиллаж байгаа ба Аймгийн 70 жилийн ойн баярын өмнө дуусгахаар төлөвлөсөн болно. Буянт сумд шинээр соёлын төв барих зураг төслийн ажил бүрэн хийгдсэн ба хөрөнгийн асуудлыг 2010 багтаан шийдвэрлэхээр болсон.

Хэрэгжих шатандаа-50%

1.2.25.3. Хөдөө орон нутгийн алслагдсан хүн амыг мэдээллээр хангах хүрээ, хүртээмжийг нэмэгдүүлж, "Явуулын номын сан"-гийн үйлчилгээг нэвтрүүлнэ.

Хэрэгжээгүй-0

1.2.28.3. Үндэсний түүх, нүүдлийн соёлоо судлан сурталчлах, монгол бичгээ өвлүүлэхэд төрөөс дэмжлэг үзүүлж, "Монгол бичиг", "Морин хуур, уртын дуу", "Монгол хөөмий", "Монгол бий биелгээ", "Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалах, сэргээн засварлах" хөтөлбөрүүдийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

Биелэлт- Сумдын соёлын төвүүдийн үйл ажиллагааг тогтмолжуулан ажиллах нөхцөл бололцоог хангахад чиглэсэн олон талын арга хэмжээ авч байна. Үндэснийхээ соёл урлагийн өвийг хамгаалах сэргээн хөгжүүлэх эрхийг хангах хүрээнд ардын язгуур урлагийн уралдаан тэмцээнийг тогтмол явуулж уламжлалт зан үйлээ хадгалах эрхийг баталгаажуулж байна. Бүргэдчдийн баяраар казах үндэсний уламжлалт наадгайг явуулахын хамт урианхай түмний ардын урлагийн наадмыг жил бүр зохион байгуулж байна. Аймгийн хэмжээний бүх сургуулиуд болон соёлын төвүүдийн дэргэд морин хуур, уртын дуу, хөөмий, бие-биелгээний чиглэлээр сургалтын дугуйлангууд тогтмол ажиллаж байгаагаас гадна аймгийн төвд угсаатны цөөнхөд үндэсний язгуур урлагийг зааж сургах төв байгуулан ажиллуулаж байгаа.

Хэрэгжих шатандаа-30%

1.3. Хөдөлмөрийн зах зээл, хөдөлмөр эрхлэлтийн бодлого

1.3.1.2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх бодлогыг аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн санаачилгад тулгуурлан орон нутаг, бүсийн хөгжил, салбарын бодлоготой уялдуулан хэрэгжүүлнэ.

Биелэлт- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үндэсний хөтөлбөрийн хүрээнд өрхийн 1-ээс доошгүй иргэнийг ажилтай болгох зорилт тавьж, 2009 онд ажилд зуучлах, төсөл хөтөлбөрт хамруулах замаар хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны хүрээнд 227 шинэ ажлын байр, улсын болон хувийн хөрөнгө оруулалтаар 1293 шинэ ажлын байр, нийт 1520 шинэ ажлын байр бий болсон. 2009 онд иргэдэд 9,3 тэрбум төгрөгийн халамжийн үйлчилгээ үзүүлсэн нь 2008 оныхоос 1,0 тэрбум төгрөгөөр илүү байна.

Хэрэгжих шатандаа-50%

1.3.6.2. "Нэг өрх-нэгээс доошгүй ажлын байр" хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.

хэрэгжээгүй -0

1.3.7.1. Эрэлтэд тулгуурласан "Эрхийн бичиг"-ийн сургалтыг орон нутагт өргөжүүлнэ.

Хэрэгжээгүй-0

1.3.15.1. Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв болон техникийн боловсролын сургуульд суралцагчдын тоог гурав дахин нэмэгдүүлнэ.

Биелэлт- Аймгийн мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэн 2009 оны хичээлийн жилд хүүхдийн тоог нэмэгдүүлэн 502 хүүхэд авч улмаар 18 мэргэжлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулах цэгүүдийг тус сургуулийн дэргэд байгууллаа.

Хэрэгжих шатандаа-50%

1.4. Нийгмийн хамгааллын бодлого

1.4.1.1. Нийгмийн ажилтнуудыг мэргэшүүлэх, тэдний ёс зүйн хэм хэмжээг тогтоон мөрдүүлэх арга хэмжээ авна.

Биелэлт- Нийгмийн ажилтнуудын аймгийн зөвлөлгөөн хийж, сургалт зохион байгуулан чадваржуулах арга хэмжээ авсан.

Хэрэгжих шатандаа-10%

1.4.6.1. Нийгмийн халамжийн үйлчилгээг хүргэж буй төв болон орон нутгийн байгууллагуудын ажил үүргийн зохион байгуулалтыг сайжруулж, нийгмийн хамгааллын үйлчилгээг хүнд сурталгүй, ил тод, шуурхай болгох арга хэмжээ авна.

Биелэлт- НХХЯамтай хамтран нийгмийн халамжийн ажилтнуудын сургалтыг 2 удаа хийж, компьютерээр бүрэн хангасан, нээлттэй хаалганы өдрүүдийг аймгийн төв, сумдад зохион байгуулсан, нийгмийн халамжийн байцаагчдын орон тоог нэмсэн.

Хэрэгжих шатандаа-30%

1.4.11.2. "Өрхийн хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр"-т үндэслэн бүс нутгийн болон эдийн засаг, дэд бүтцийн хөгжилтэй уялдсан арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлнэ.

Хэрэгжээгүй-0

1.4.12.1. Хувийн хэвшил, иргэдийн оролцоо, санаачилгад тулгуурлан "Өрхийн хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлнэ.

Хэрэгжээгүй-0

1.4.12.2. "Өрхийн хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр"-т хамрагдах өрхийг сонгох, өрхийн хөгжлийн төлөвлөгөө гаргах аргачлалыг боловсруулна.

Хэрэгжээгүй-0

1.4.12.3. "Өрхийн хөгжлийн төлөвлөгөөнд үндэслэн тухайн өрхийг хөгжүүлэх, амьжиргааг дээшлүүлэх ажлыг хувийн хэвшил, иргэний нийгмийн оролцоотойгоор зохион байгуулж, хөтөлбөрт хамрагдсан өрхийн мэдээллийн сан байгуулна.

Биелэлт- Өрхийн хэрэгцээ, чадавхийг дээшлүүлэх арга хэмжээний хүрээнд "Бизнес эхлэл" "Бизнес хөгжил" "Жижиг зээлийн төсөл боловсруулах" сургалтыг зохион байгуулж, 160 иргэнийг хамруулсан.

Хэрэгжих шатандаа-10%

1.4.12.4. Нутгийн захиргааны байгууллага, хувийн хэвшил, иргэний нийгмийн ядууралтай тэмцэх чадавхийг бэхжүүлэх арга хэмжээг дэс дараатай хэрэгжүүлнэ.

Биелэлт- 2009 онд ажилгүйдлийн тэтгэмжинд 138 хүнийг хамруулж 92,8 сая төгрөгийг олгосон. Мөн 198 иргэнд 19367,6 мянган төгрөгийг зээлийн хүүгийн нөхөн төлбөр олгож тусалсан. Ажил олгогчдын аймгийн зөвлөлгөөн хийж, тэргүүний ажил олгогч шалгаруулах болзол зарлаж дүгнэсэн.

Хэрэгжих шатандаа-30%

1.4.15.1. "Хүн байхын учир" аяныг өргөжүүлж, хүүхэд, өсвөр үеийнхний "Гэр бүлдээ үүнийг хүснэ", "Миний паспорт", "Миний нэрийн хуудас" зэрэг хөдөлгөөн, үүсгэл санаачилгыг бүх талаар дэмжинэ.

Биелэлт- “Хүн байхын учир” сэдвийн дагуу эрүүл аж төрөх, өөрийн амьдарч буй орчноо цэвэр байлгах талаар “Цэвэр, эрүүл орчинд амьдарцгаая” аяныг 2 удаа зохион байгууллаа. “Миний нэрийн хуудас аяны хүрээнд анги хамт олноороо Сайн сурлагатан хүүхдүүдийг оролцуулан сурсан зүйлээ бусдад зааж сургах үйл ажиллагаа явуулсан. Жил бүр “Миний ирээдүй” сэдэвтэй зохион бичлэгийн уралдаан зохион явуулдаг боллоо. Ахлах ангийн сурагчдад зориулан “Ирээдүйн босго” клубээс ХДХВ-ын өвчний талаар ангиараа болон ганцаарчилсан хэлбэрээр сургалт зөвлөгөө өгч ажиллаж байна.

Хэрэгжих шатандаа-50%

1.4.15.2. Хүүхэд амралт, чөлөөт цагаа өнгөрөөж, мэдээлэл авч байгаа байдалд судалгаа хийж, хүүхэд, өсвөр үеийг хариуцлагатай, бүтээлч тусч энэрэнгүй, нийгмийн идэвхтэй иргэн болгож, төлөвшүүлэх талаар эцэг, эх, гэр бүлийн гишүүдийн мэдлэг хандлагыг өөрчлөх сургалт, сурталчилгааг өргөжүүлэх чиглэлээр ТББ-уудтай хамтран ажиллана.

Биелэлт- Хүүхдийг амралт чөлөөт цагаар нь ашигтай мэдээллээр хангах зорилгоор хүүхдэд зориулагдсан “Жаухазын” радио нэвтрүүлэг явуулж, Хүүхдийн төлөө хэлтсийн “Болашах” сонингоор хүүхдүүдэд мэдээлэл авах боломж бүрдүүлсэн. Аймгийн ЗДТГ, Хөгжмийн драмын театр хамтран ОХУ-ын Алтай хязгаарт олон улсын язгуур урлагийн тэмцээнд 20 хүүхдийг оролцуулсан ба багаараа 1-р байр эзэлсэн. Цаашид энэ чиглэлийн хамтын ажиллагааг өргөжүүлнэ.

Хэрэгжих шатандаа-50%

1.4.15.3. Хүүхэд, өсвөр үеийнхний дунд эрүүл амьдралын дадал хэвшүүлэх, зохистой хооллолтыг эрхэмлэх, хорт зуршлаас татгалзах мэдлэг чадварыг нэмэгдүүлэх талаар сургалт, сурталчилгааг өргөжүүлнэ.

Биелэлт- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд ТББ-тай хамтран өсвөр үе залуучуудад зориулан 2 удаа сургалт явуулсан. Эрүүл мэндийн байгууллагаас тогтмол эмнэлгийн үзлэг хийх, хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр сурталчилгаа явуулах, өсвөр үе - гэр бүл” гэсэн сэдэвтэй зөвлөгөө өгөх байр нээн ажиллуулж байна. Аймгийн хэмжээнд гэмт хэрэг, хэв журмын зөрчил гаргасан хүүхдийн үйлдсэн гэмт хэрэг 5,8%-иар буурсан үзүүлэлттэй байна. Цагдаагийн хэлтэст хүүхдүүдээс мэдүүлэг авах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөгөө өгөх танхимийг Дэлхийн Зөн ОУБ-ын санхүүжилтээр шинээр байгуулан ажилуулж байна.

Хэрэгжих шатандаа-50%

1.5. Хүн амын бодлого

1.5.2.2. "Гэр бүлийн хөгжлийг дэмжих жил"-ийг зарлана.

хэрэгжээгүй-0

1.5.6.3. Ахмадууд нийгмийн амьдралд идэвхтэй оролцох, тэдний чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх боломжийг бүрдүүлэх, чанартай насжилтыг дэмжих зорилгоор аймаг, дүүрэг бүрт орон нутгийн нөөц хөрөнгө, бололцоог ашиглан ахмадын ордон байгуулж ашиглалтад оруулна.

Биелэлт- Аймгийн Ахмадын ордны барилгын зураг төсвийг нь хийлгэж, УИХ-д асуудал тавьсаны үндсэнд 2010 оны улсын төсвөөс Ахмадын өргөө барихад 373,0 сая төгрөг хувиарлагдсан. 2010 онд барилгын ажлыг эхлүүлнэ.

Хэрэгжих шатандаа-30%

1.5.10.1. Хүүхэд, тэдний өөрийн удирдлагын байгууллага, хөдөлгөөн, хүүхдийн нэгдсэн зөвлөлийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхийн зэрэгцээ хүүхдийн хэрэгцээ шаардлагыг харгалзан тэдний санал хүсэлтийг шийдвэртээ тусгаж ажиллах талаар нутгийн захиргааны байгууллагыг зөвлөмжөөр хангаж ажиллана.

Биелэлт- “Ирээдүй хүүхэд наснаас эхэлдэг” сэдэвтэй хүүхдийн нэгдсэн Зөвлөлд олон хүүхдийг хамруулж тулгамдаж буй асуудлыг өөрсдөө шийдвэрлэх, багаар ажиллах, багшаас зөвлөгөө авах зэрэг ажлуудыг зохион байгууллаа. Хүүхдийн оролцооны байгууллага болох

Хүүхдийн нэгдсэн зөвлөл “Сэтгэлийн Зөн” ХӨУЗ-ын үйл ажиллагааг идэвхжүүлэх зорилгоор хүүхдийн нэгдсэн чуулганыг хийж, уг чуулганаас АХНЗ-ийн ахлах сургагч болон бусад идэвхтнүүдийг 13 хүүхдийн бүрэлдэхүүнтэйгээр сонгон ажиллуулж байна. АХНЗ-ийн салбарыг сум бүрт байгуулан чуулганы үеэр идэвхтнүүдийн арга зүйн сургалтыг зохион явуулж НҮБ-ын Хүүхдийн сангийн дэмжлэгтэйгээр хэвлэгдсэн анхан шатны зөвлөл, бүлгийн ажил явуулах аргачлал номоор ханган ажиллаж байна.

Хэрэгжих шатандаа-50%

ХОЁР. ҮЙЛДВЭРЖҮҮЛЭЛТИЙН БОДЛОГО ХЭРЭГЖҮҮЛСНЭЭР ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ЗОРИЛТ

2.1. Макро эдийн засаг, санхүүгийн бодлого

2.1.1.1. Эдийн засгийн салбаруудын үйл ажиллагааг өргөжүүлэх замаар өсөлтийг нэмэгдүүлнэ.

Биелэлт- Аймгийн ДНБ-ний тооцоог ҮСХ-оос хүргүүлсэн үндэсний тооцооны системийг “ҮТС-93” аргачлал, зааврын дагуу хийж, эдийн засгийн бодит сектор болон албан бус эдийн засгийн салбарын тооцоог оруулан тооцсоноор ДНБ-ний тооцоонд бүгд 380 ААН байгууллагыг хамруулав. ДНБ-ний тооцоонд хамрагдсан нэгжийн тоо 44 буюу 13,1%-иар нэмэгдсэн. Эдийн засгийн салбар бүрээр хувийн аж ахуй, албан бус секторыг оруулан тооцсноор аймгийн дүнгээр 79,8 тэрбум төгрөгийн нэмэгдэл өртөг гарч өмнөх оныхоос 8,7%-иар өссөн байна. ДНБ-ний 57%-ийг ХАА, 39,7%-ийг үйлчилгээний салбар, 3,3%-ийг аж үйлдвэр, барилга зэрэг дэд бүтцийн салбар бүрдүүлж байна.

Хэрэгжих шатандаа-50%

2.1.2.1. Үндэсний хөгжлийн цогц бодлоготой уялдуулан Төсвийн хүрээний дунд хугацааны мэдэгдэл, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх жил бүрийн үндсэн чиглэлийн шалгуур үзүүлэлтийг боловсронгуй болгож, дунд болон урт хугацааны бодлогыг хэрэгжүүлэх санхүүгийн төлөвлөлт, зохицуулалтыг сайжруулна.

Биелэлт- Баян-Өлгий аймгийг 2010-2020 онд хөгжүүлэх хөтөлбөр боловсруулан ИТХ-аар батлуулан хэрэгжүүлэх ажилд орсон. Аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн шалгуур үзүүлэлтийг дунд болон урт хугацааны бодлого зорилттой уялдуулах ажлыг эхэлсэн.

Хэрэгжих шатандаа-30%

2.1.2.2. Ажилгүйдэл, ядуурлыг бууруулж, иргэдийн амьдралын түвшинг дээшлүүлэх үндэсний тооцооны шалгуур үзүүлэлт, тэдгээрийн хүрэх түвшин, хөрөнгө оруулалтын хэрэгцээг оновчтой тодорхойлж, эдийн засгийн тогтвортой өсөлт, хөгжлийн тэнцвэрийг бататгах макро эдийн засгийн зохицуулалтын орчныг сайжруулна.

Биелэлт- Аймгийн хэмжээний ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, шинэ ажлын байр олноор бий болгох зорилтыг цаг алдалгүй хэрэгжүүлэх ажлын шаардлагыг харгалзан “Аймгийн ажил олгогчид, эздийн зөвлөгөөн”-ийг 2009 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр Өлгий суманд зохион байгуулж, ажил олгогч нарт мэргэжил арга зүйн зөвлөлгөө өгч, 2.0 сая төгрөгийн шагналын сан бүхий “Шилдэг ажил олгогч шалгаруулах болзол” зарласан болно. 2009 оны 12 дугаар сарын 01-ны байдлаар 1539 шинэ ажлын байр бий болгож, 1560 хүнийг ажилд зуучилсан. Шилдэг ажил олгогч шалгаруулах бозлыг 12 дугаар сард дүгнэж, хамгийн олон ажлын байр бий болгосон. “Монстрой”, “Көшелик”, ЦШСГ зэрэг байгууллага, аж ахуйн нэгжийг шалгаруулж шагнасан. Албан бус хөдөлмөр эрхлэгчдийн бүртгэл мэдээлэл, нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд хамрагдалтыг сайжруулах зорилгоор “Улсын үзлэг зохион байгуулах тухай” НХХ-ийн сайдын 2009 оны 109 тоот тушаалыг үндэслэн ажлын хэсэг байгуулж, 3 шатны үзлэгийг зохион байгуулж нийт 2226 иргэнийг албан бус хөдөлмөр эрхлэгч гэж бүртгэн сүлжээнд оруулж, нийгмийн даатгалын сайн дурын даатгалд 350 иргэнийг хамруулжээ. 2009 онд ажилгүйдлийн тэтгэмжинд 138 хүнийг хамруулж 92,8 сая төгрөгийг олгосон. 2009 онд 198 иргэнд 19367,6 мянган төгрөгийг зээлийн хүүгийн нөхөн төлбөр олгож тусалсан.

Хэрэгжих шатандаа-50%

2.1.2.6. Улсын төсвийн болон Монгол Улсыг хөгжүүлэх сангийн хөрөнгө оруулалт, санхүүгийн дэмжлэгийг бүсийн тулгуур төв, орон нутгийн хөгжлийн төв, арга хэмжээтэй уялдуулан хуваарилж хэрэгжүүлнэ.

Биелэлт- Аймгийн хөгжлийн хөтөлбөр боловсруулан, аймгийн хэмжээнд эхний ээлжинд санхүүгийн дэмжлэг, хөрөнгө оруулалт шаардлагатай тэргүүлэх чиглэлүүдийг тогтоосон.

Хэрэгжих шатандаа-30%

2.1.10.1. “Хувийн хэвшлийн хөгжлийн стратеги”-ийг батлуулан төр, хувийн хэвшлийн түншлэлийг сайжруулна.

Биелэлт- “Хувийн хэвшлийн хөгжлийн стратеги” батлагдаагүй, судалгааны түвшинд байгаа.

Хэрэгжих шатандаа-10%

2.1.14.1. Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулах эрх зүйн баримт бичгүүдийг батлан мөрдүүлнэ.

Биелэлт- Асгатын мөнгөний ордыг ашиглах асуудлаар санал боловсруулан байнга хөөцөлдөж байгаа, УИХ, Засгийн газар дэмжиж байгаа.

Хэрэгжих шатандаа-10%

2.1.27.3. Шудрага өрсөлдөөнийг дэмжих, хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах бодлого боловсруулж хэрэгжүүлнэ.

Биелэлт- “Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах” үндэсний хөтөлбөр батлагдаж, хэрэгжих шатандаа байна.

Хэрэгжих шатандаа-10%

2.1.27.4. Зах зээлийн өрсөлдөөний тухай ойлголт, соёлыг төлөвшүүлэх чиглэлээр сургалт, сурталчилгаа, үндэсний болон олон улсын хэмжээний хурал, семинар зохион байгуулна.

Биелэлт- Ажил олгогчдын аймгийн зөвлөлгөөн, сум төсөвт албан байгууллагын дарга эрхлэгчдийн сургалт семинарын үеэр зах зээлийн өрсөлдөөн, соёлын талаар хичээл заасан. Аймгийн радиогоор зах зээлийн үнэ ханшийн мэдээллийг тогтмол өгч байна.

Хэрэгжих шатандаа-30%

2.1.28.4. Бүсийн болон аймгийн төвд сорилт, хэмжил зүйн үйлчилгээг нэг цэгийн зарчимд шилжүүлнэ. Хэрэглээний зүйлс, барилга, хүрээлэн буй орчны чанар, аюулгүй байдлын сорилт, шинжилгээг орчин үеийн шаардлагын хэмжээнд хийдэг сорилын лабораторийн үндэсний тогтолцоог бий болгоно.

Биелэлт- Аймгийн МХГазар, Стандартчилал, хэмжил зүйн хэлтсийн лаборатори, тоног төхөөрөмжийг шинэчлэх бодлого, чиглэл баримталж мэргэжлийн хяналтын газрын лабораторийг шинэчилсэн. Цагааннуурын хилийн боомтонд хилийн хяналтын лаборатори байгуулсан.

Хэрэгжих шатандаа-10%

2.2. Үйлдвэржүүлэх бодлого

2.2.5.1. Боловсруулах үйлдвэрийн үндсэн салбаруудыг харилцан уялдаа бүхий хоршилт, төрөлжсөн хэлбэрээр хөгжүүлж, эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн өсөлтийг хангах цогцолборууд байгуулна.

Хэрэгжээгүй-0

2.2.5.2. Газар зүйн заалттай бүтээгдэхүүн бий болгох ажлыг эрчимжүүлж, нэр төрлийг олшруулна.

Биелэлт- Гурилын үйлдвэр байгуулах асуудлыг судалж, ОХУ болон Казахстан Улсад асуудал тавьж хөөцөлдөж байна. Судалгааны шатанд байна.

Хэрэгжих шатандаа-10%

2.2.5.3. Салбарын эрдэм шинжилгээний байгууллагын чадавхийг дээшлүүлэн, шинжлэх ухаан үйлдвэрлэлийн хамтын ажиллагааг идэвхжүүлнэ.

Хэрэгжээгүй-0

2.2.5.4. Боловсруулах үйлдвэрүүдийн мэргэжилтэй ажилчин, инженер техникийн ажилтан бэлтгэх тусгай хөтөлбөр баталж хэрэгжүүлнэ.

Биелэлт- 2009 онд мэргэжил, ур чадвар олгох сургалтанд 530 хүн, аж ахуй эрхлэх, бизнесийн сургалтанд 168 хүн, төсөл боловсруулах сургалтанд 68, үйлдвэр дээрх сургалтанд 9, давтан сургалтанд 47 хүн, нийт 822 хүнийг хамруулж, уг арга хэмжээнд ХЭДСангаас 65,0 сая төгрөг зарцуулсан байна. Уг сургалтанд оролцогчдоос 419 хүн ажлын байраар хангагдсан байна.

Хэрэгжих шатандаа-30%

2.2.6.1. Уул уурхайн үйлдвэрийг түшиглэн барилгын материалын үйлдвэр орон нутагт байгуулахыг дэмжинэ./2010-2011/

Биелэлт- Толбо сум, Өлгий сумдын төвд улаан тоосгоны үйлдвэрийг барьж ашиглалтад оруулсан. Барилгын чиглэлээр 5 хүнд 48,0 сая төгрөгний зээл олгож, үйл ажиллагаанд хяналт тавин ажиллаж байна. Сагсай сумд цементийн үйлдвэр барих талаар БНХАУ-тай гэрээ хийж, хэрэгжих шатанд явж байна. Түлшний үйлдвэр байгуулах төсөлд 50,0 сая төгрөгийн зээл олгосон.

Хэрэгжих шатандаа – 50%

2.2.7.4. Орон нутагт үйлдвэр хөгжүүлэх үндсэн чиглэлийг нарийвчлан тогтоож, бүс нутгаар үйлдвэр, үйлчилгээг төрөлжүүлэн хөгжүүлнэ.

Биелэлт- Засаг даргын 2009 оны 6-р сарын 16-ны өдрийн 248 тоот захирамжаар 7 хүний бүрэлдэхүүнтэй төсөл сонгон шалгаруулах дэд комисс 3 удаа хуралдаж нийт 11,7 тэрбум төгрөгийн 224 төсөл хүлээн авч, сонгон шалгаруулж 83 аж ахуйн нэгж, иргэдэд 763 сая төгрөгийн зээл олгосон. 38 аж ахуйн нэгж, иргэн 10 саяас дээш төгрөгийн зээл авсан бөгөөд 4 нь хөдөө сумдад 34 нь аймгийн төвд байна. Үүнээс зээл олголтыг салбараар нь авч үзвэл хүнсний үйлдвэрийн 8 буюу 8,3 хувь, ХАА 42 буюу 50,6 хувь, Хөнгөн үйлдвэрийн 5 буюу 6 хувь, Барилгын материалын 12 буюу 14,3 хувь, эм бэлдмэлийн 1 буюу 1,2 хувь, ахуйн үйлчилгээний 8 буюу 9,6 хувь, худалдаа үйлчилгээний 7 буюу 8,4 хувийг тус тус эзэлж байна. Эдгээр аж ахуйн нэгж, иргэдийн 10% нь шинээр үйлдвэрлэл эрхлэх, 90 хувь нь үйлдвэрлэл үйлчилгээ, бизнесээ өргөтгөх чиглэлээр зээлд хамрагдсан байна. 2009 оны 11-р сард 10 саяас дээш төгрөгийн зээл авсан иргэн аж, ахуйн нэгжийн зээлийн хэрэгжилт, үр дүнг газар дээр нь шалгаж үзэхэд 70 хувь нь үйл ажиллагаагаа эхэлж, авсан зээлийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулж байгаа, 30% нь янз бүрийн шалтгаанаар үйл ажиллагаагаа эхлээгүй байжээ.

Хэрэгжих шатандаа-30%

2.2.7.5. Аймаг, сумдын 10, 15, 35 кв-ын шугамын трассын дагуу дундын хэрэглэгчдийг хамруулж жижиг трансформаторын дэд станц барих бодлого баримталж ажиллан, орон нутагт инженерийн хийцтэй худаг гаргах усны хайгуулын зарим ажлыг сумдын цахилгаан дамжуулах агаарын шугамын дагуу хийнэ.

Биелэлт- Улаанхус сум-Согогийн баг, Цагааннуур-Улаанбайшинтын чиглэлийн 10 кВт-ын болон Өлгий-Цагааннуур-Ногооннуур сумыг холбосон 35 кВт-ын ЦДАШ-ыг дэд станцын хамт барьж ашиглалтанд оруулсны дээр Ховдын Дуутаас Өлгийн Булган сум хүртэлх 15 кВт-ын 109 км ЦДАШ-ын 1,3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй барилгын үндсэн ажлыг хийж, ирэх оны эхний хагаст багтаан ашиглалтанд авахад бэлэн болгосноор аймгийн нийт сумдыг баруун бүсийн эрчим хүчний нэгдсэн системд бүрэн холбох томоохон зорилтыг шийдвэрлэх боломж бүрдэж байна.

Хэрэгжих шатандаа-70%

2.2.28.1. "Сүү" хөтөлбөрийг хэрэгжүүлж, махны нөөцийн сан байгуулна.

Биелэлт- Өлгий хотын төв болон Баяннуур сумын 95 үнээнд сайн үүлдрийн бухны гүн хөлдөөсөн үрээр зохиомол хээлтүүлэг хийгээд байна. Өлгий суманд сүүний чиглэлийн бичил фермерүүд байгуулагдаж эхэлсэн.

Хэрэгжих шатандаа-30%

2.2.30.1. "Чацаргана" хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.

Хэрэгжилт-0%

2.3. Хөдөө аж ахуй, хүнсний аюулгүй байдлын бодлого

2.3.1.2. Сүүний хангамжийг нэмэгдүүлэн, сүү, сүүн бүтээгдэхүүний чанар, ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагыг сайжруулан, удаан хугацаагаар хадгалагдах сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжинэ.

Биелэлт- 2008-2009 онд 10-15 үнээтэй сүүний чиглэлийн 5 мини фермер байгуулагдсан. ХХААХҮЯамнаас 4 фермерт тус бүр 5 үнээ өгөхөөр шийдвэрлэж, эхний 2 фермерт 10 үнээ олгосон, үйл ажиллагаагаа явуулж байна. Сүү боловсруулах жижиг цехийн зөвшөөрлийг хүнсний "Азых" ХК, "Нурарда" хоршоо, "Бексарана" хоршоодод олгосон болно.

Хэрэгжих шатандаа-30%

2.3.1.3. Малчид, фермерүүдийн сүүг сүү үйлдвэрлэгчид нэгдсэн байдлаар цуглуулах, хөргөх, боловсруулах сүү бэлтгэлийн тогтолцоог бүрдүүлэн ажлын байр нэмэгдүүлж, хүн амын амьжиргаа, хүнсний аюулгүй байдлыг хангана.

Биелэлт- Хот суурин газрын сүүний хангамжийг сайжруулах зорилгоор зарласан тендерт "Сүүний чиглэлийн үхэр үржүүлэх" төслөөр 0165 дугаар цэргийн анги, "Азык" ХХК-ны төсөл шалгарч, тус бүр сүүний чиглэлийн тав, таван үнээ авч маллаж байна. Дэлхийн Зөн ОУ-ын байгууллагын "Малчдын амьжиргааг дээшлүүлэх төсөл", орон нутгийн хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд "Алатау" үүлдрийн 16 үнээг Өлгий, Цэнгэл, Баяннуур сумдын малчдын бүлэг, хоршоодод үнэгүй өгсөн. Мөн ЖДҮ хөгжүүлэх чиглэлээр 24 ААН, байгууллагад 211,0 сая төгрөгний хөнгөлөлттэй зээл олгож, үйл ажиллагаанд нь хяналт тавин ажиллаж байна.

Хэрэгжих шатандаа-30%

2.3.1.4. Буудайн гурилыг амин дэм, эрдэс бодисоор баяжуулахад шаардагдах холигч төхөөрөмж, премиксийг хөнгөлөлттэй нөхцөлөөр нийлүүлнэ.

Биелэлт- ХХААХҮЯамны хөнгөлөлттэй зээлээр "Аулет" ХХК хоногт 18 тонн гурил 6 тонн хивэг үйлдвэрлэх хүчин чадалтай үйлдвэр баригдаад тоног төхөөрөмжөө суурилуулаад байна. Энэ үйлдвэр нь гурилыг амин дэм эрдэс бодисоор баяжуулж хийхээр Яамтай гэрээ хийсэн байна.

Хэрэгжих шатандаа-30%

2.3.1.5. "Ногоон хувьсгал" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

Биелэлт- Ногоон хувьсгал хөтөлбөрийг аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдээр байгуулан мөрдөж ажиллаж байна. Аймгийн хэмжээгээс 4000 гаруй өрх өрхийн тариалан эрхэлж, 320 га газар төмс 110га-д хүнсний ногоо тариалж, 3200 тонн төмс 1200 тонн хүнсний ногоо хураан авч хэрэгцээт төмсний 70%, хүнсний ногооны 17%-ийг хангаад байна.

Хэрэгжих шатандаа-50%

2.3.1.6. Дотоодын хүнсний түүхий эдэд тулгуурласан нярай хүүхдийн хоол болон түүнд чиглэсэн үйлчилгээтэй хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэгчлийг бодлогоор дэмжинэ.

Биелэлт- Энэ чиглэлээр үйлдвэр үйлчилгээ эрхлэгчдэд мэдээлэл өгсөн судалгааны шатанд байна.

Хэрэгжих шатандаа-10%

2.3.5.1. Тариалангийн талбайн бүртгэл, тооллого явуулж, эзэмшилт, ашиглалтыг сайжруулна.

Биелэлт- Аймгийн хэмжээний тариалангийн талбайн тооллого явуулж, атаршсан 200 га талбайг иргэдэд эзэмшүүлж өгсөн. Тариаланд тохиромжтой Бугат, Баяннуур, Ногооннуур, Алтанцөгц, Сагсай сумдын талбайг газар тариалан эрхлэх сонирхолтой иргэдэд эзэмшүүлсэн.

Хэрэгжих шатандаа-50%

2.3.5.2. Таримал ургамал, үр үржүүлгийн аж ахуй байгуулах, үрийн сорт, нэр төрлийг олшруулах, ганд тэсвэртэй болон усалгаатай нөхцөлд тариалах сортын үрийн хангамжийг нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Биелэлт- Тус аймгийн хувьд хөрс цаг уурын онцлогоос шалтгаалан үр үржүүлгийн аж ахуй байгуулах боломжгүй. Баяннуур сумын Ахтолхын хоршоо, халтар арвай, лууван, шар манжины үр үржүүлэх туршилт хийж байна. Ховд голын сав дагуух сумдад агропарк байгуулсан, өрхийн тариалан эрхлэгчдийг гадаад, дотоодын сайн чанарын төмс, ногооны үрээр хангаж байна.

Хэрэгжих шатандаа-10%

2.3.5.3. Улаан буудайн нөөц бүрдүүлэх, хүрэлцээ хангамжийг сайжруулах зорилгоор борлуулалтын сүлжээ бий болгоно.

Биелэлт- Тус аймагт улаан буудайн үйлдвэрлэл байхгүй, харин Казахстан улсаас улаан буудай авах талаар хөөцөлдөж байна.

Хэрэгжих шатандаа-10%

2.3.5.4. "Атрын 3 дахь аян" тариалангийн хөгжлийн үндэсний хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

Биелэлт- Атрын гурав дахь аян дэд хөтөлбөр боловсруулж ИТХ-ын тэргүүлэгчдээр батлуулан ажиллаж байна. Аймгийн хэмжээний тариалангийн талбайн тооллого явуулсан. Атаршсан 200га талбайг эргэлтэнд оруулсан. Аймгийн хэмжээнд 4000 өрх их бага хэмжээгээр өрхийн тариалан эрхэлж 320 га-д төмс, 110 га-д хүнсний ногоо тариалж, 3200 тонн төмс, 1100 тонн хүнсний ногоо хурааж авсан.

Хэрэгжих шатандаа-50%

2.3.5.5. Улаан буудайн үйлдвэрлэлд төрөөс дэмжлэг хэлбэрээр үзүүлэх урамшууллын системийг боловсронгуй болгоно.

Биелэлт- Баян-Өлгий аймгийн хувьд улаан буудай тариалдаггүй.

Хэрэгжилт-0%

2.3.6.1. Нутгийн болон сайжирсан, цэвэр үүлдрийн малын удмын санг хамгаалах, өсгөх, мал үржүүлгийн болон биотехнологийн дэвшилтэт аргыг нэвтрүүлэх замаар мал аж ахуйн үйлдвэрлэлийн бүтээмжийг нэмэгдүүлнэ.

Биелэлт- Аймгийн төв болон Баяннуур сумын 95 үнээнд сайн үүлдрийн бухны гүн хөлдөөсөн үрээр зохиомол хээлтүүлэг хийгдсэн. Сүүний үүлдрийн бухны үрээр зохиомол хээлтүүлэг хийхээр 50 яамааг тусгайлан суурилж бэлтгэл ажил хийгдээд байна, Баяннуур сумын "Уулын бор" үүлдрийн яамаа, Дэлүүн сумын Керейн үүлдрийн "Уурцан сүүлт" хонийг сонгон үржүүлэх ажлыг хийж байна. Цаашид жил бүр 100-аас доошгүй үнээнд зохиомол хээлтүүлэг хийхээр төлөвлөж байна.

Хэрэгжих шатандаа-50%

2.3.6.2. Цаа буга, тэмээний удмын сан, эрүүл мэндийг хамгаалах, өсгөх, ашиг шимийг зохистой ашиглах замаар цаачид, тэмээчдэд дэмжлэг үзүүлнэ.

Биелэлт- Баяннуур, Алтанцөгц, Өлгий, Улаанхус сумдад ингэний жижиг ферм байгуулах эхлэл тавигдаж байна. Энэ санаачилгыг нутгийн захиргааны байгууллага дэмжиж байна.

Хэрэгжих шатандаа-10%

2.3.6.3. Цөм сүргийн малыг үржлийн бүртгэлд бүрэн хамруулж, улсын хэмжээнд үржүүлж байгаа арвин ашиг шимт цөм сүргийн малын удам гарваль, ашиг шимийн мэдээллийн сан бий болгоно.

Биелэлт- Цөм сүргийн үржлийн нэгж Алтай, Дэлүүн, Баяннуур сумдад байгуулагдаад үйл ажиллагаагаа явуулж эхлээд байна. Цаашид бүх суманд үржлийн нэгж байгуулж, үржлийн ажлыг шинжлэх ухааны үндэстэй явуулах бодлого барьж байна.

Хэрэгжэх шатандаа-30%

2.3.6.4. Малын үржлийн ажил үйлчилгээний хүртээмж, үр дүнг сайжруулах зорилгоор цөм сүргийн үржлийн нэгжийн чадавхийг сайжруулах асуудлыг судалж холбогдох арга хэмжээг авна.

Хэрэгжилт-0%

2.3.7.1. Эрчимжсэн мал аж ахуй эрхлэх бүс нутгуудыг аймаг, сум бүрээр тусгайлан тогтоож, тухайн бүс нутагт буй бэлчээрийн малыг өндөр ашиг шимт малаар сольж, өөрчлөх хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлнэ.

Биелэлт- Эрчимжсэн аж ахуйн хөгжлийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд өмнө нь байсан сүүний чиглэлийн фермерүүдийн үнээг өндөр ашиг шимт бухын гүн хөлдөөсөн үрээр хээлтүүлэг хийсэн. 2010 онд эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэхэд 3,6 сая төгрөг орон нутгийн төсөвт тусгуулахаар оруулсан боловч, хөрөнгийн эх үүсвэргүйгээс батлагдаагүй. Цаашид Бугат, Баяннуур, Ногооннуур, Алтанцөгц сумдыг эрчимжсэн аж ахуй хөгжүүлэх бүс нутаг болгохоор бодлого боловсруулж байна.

Хэрэгжих шатандаа-30%

2.3.7.2. Сүү, махны арвин ашиг шимт мал, амьтны тоог нэмэгдүүлэх, үржлийн сүрэг бий болгох үйл ажиллагааг урамшуулна.

Биелэлт- Аймагын төвийн ойролцоо сүүний чиглэлийн фермерийн аж ахуй байгуулсан 5 аж ахуйн нэгжид тус бүр сайн үүлдрийн 5 үнээ өгөхөөр ХХААХҮ-ийн Яамнаас шийдвэрлэж 2 аж ахуйн нэгж 10 үнээ аваад байна. Мөн аймгийн төв болон Баяннуур суманд 105 үнээнд сайн үүлдрийн сүүний чиглэлийн бухны үрээр зохиомол хээлтүүлэг хийгдсэн үр дүнг энэ жил тооцох болно. Цаашид сүүний чиглэлийн үхрийн тоог нэмэгдүүлэх ажлуудыг үе шаттайгаар хийхээр төлөвлөөд байна.

Хэрэгжих шатандаа-30%

2.3.7.3. Бүсийн тулгуур төв болон орон нутгийн хөгжлийн төвүүдийн ойролцоо фермерийн аж ахуйг цогцолбор байдлаар хөгжүүлэх загвар бий болгоход дэмжлэг үзүүлнэ.

Хэрэгжээгүй-0

2.3.8.1. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний бирж байгуулан ажиллуулна.

Биелэлт- Хөдөө аж ахуйн биржийн тухай хуулийг ХХААХҮ-ийн Яамнаас боловсруулж хэлэлцүүлэг явуулж байна. Бирж байгуулах талаар 2010 он бүсчилсэн сургалт зохион байгуулахаар төлөвлөгдсөн.

Хэрэгжих шатандаа-10%

2.3.8.2. Сум бүрт түүхий эд бэлтгэлийн анхан шатны хоршоо, нөхөрлөл байгуулахад дэмжлэг үзүүлнэ.

Биелэлт- Сум бүрт түүхий эд бэлтгэдэг тодорхой хүмүүс байгаа ч хоршоо нөхөрлөлийн хэлбэрээр зохион байгуулалтад ороогүй ЖДҮ-ийг дэмжих сангаас тухайн чиглэлийг дэмжих бодлого баримталж байна. Тухайлбал Буянт суманд эсгийний жижиг үйлдвэр байгуулсан "Жолжахсы" ХХК-д 10 сая төгрөгийн зээл олгосон.

Хэрэгжих шатандаа-30%

2.3.10.1. "Малын тэжээл хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэн, тэжээл үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.

Биелэлт- Малын тэжээл хөтөлбөрийг хэрэгжүүлэх үүднээс 2009 онд ХХААҮЯ-ны дэмжлэгээр Булган сумын Цагаан эрэг, Хужирт, Улаанхус сумын Жаланагаш Сагсайн Улаан-дээл, Цэнгэлийн Хар-татарт 604 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар услалтын системийг

шинээр барих сэргээн засварлах ажил хийгдсэн. Энэ онд уг системүүдийн талбайг услах, малын тэжээл тариалах даалгавар өгөгдөөд байна.

Хэрэгжих шатандаа-30%

2.3.10.2. Хадлан болон тэжээл үйлдвэрлэлд дэвшилтэт техник, технологи нэвтрүүлж, тэжээлийн хангамж, чанарыг сайжруулах, хадгалалт, тээвэрлэлтийн зардлыг бууруулах арга хэмжээ авна.

Биелэлт- Газар тариалан эрхэлдэг, тэжээл бэлтгэдэг аж ахуйн нэгжүүдэд сүүлийн 2 жилд 18 ширхэг бага оврын трактор дагалдах хэрэгслийн хамт 50 хувийн хөнгөлөлттэй үнээр олгосон. Мэргэжил шаардахгүй, багтаамж ихтэй ажилд үр бүтээлтэй, эмзэг бүлгийн иргэдийг түлхүү оролцуулан, түр ажлын байраар хангах бодлого барьж хадлангийн талбайг өргөтгөж, бэлчээр усжуулах, ойжуулалт хийх, ашиглагдаагүй бэлчээрийн газрын замыг засах зэрэг 63 төрлийн ажлыг зохион байгуулж, тэдгээрт 1409 иргэнийг ажиллуулсан.

Хэрэгжих шатандаа-30%

2.3.11.3. Аймаг болон сум дундын отрын бүс нутгийг өргөжүүлж, материаллаг баазыг бэхжүүлнэ. Отрын бүс нутгийн бэлчээрийн нөхөн сэргээлт, хамгаалалтыг сайжруулан зохистой ашиглах арга хэмжээ авна.

Биелэлт- Улсын тусгай хамгаалалттай газар болон хилийн зурваст мал өвөлжүүлэх талаар холбогдох байгууллагуудад асуудал тавьсан. Хөх сэрхийн дархан цаазат газар 36 мянган мал, Цамбагаравт Толбо, Баяннуур, Алтанцөгц сумын 44,0 мянган мал, хилийн зурваст Улаанхус Цэнгэл, Сагсай, Алтай Дэлүүн сумдын 27,0 мянган мал отроор өвөлжиж байна. Баруун бүсэд отрын бүс байхгүй. Цаашид Увс, Ховд, Баян-Өлгий аймгуудын аймаг дундын отрын бүс нутаг тогтоох шаардлагатай байна.

Хэрэгжих шатандаа-30%

2.3.12.2. Хил дамжин халдварладаг малын гоц халдварт шүлхий, хонь, ямааны цэцэг, гахайн мялзан, шувууны томуу өвчний дэгдэлтээс эрт сэрэмжлүүлэн, хариу арга хэмжээг хэрэгжүүлэн, уг өвчнөөр тайван нөхцлийг хангаж ажиллана.

Биелэлт- Хил дамжиж халдварладаг мал, амьтан, шувууны өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар сумдад албан бичгээр мэдэгдэж, аймгийн радиогоор нийт иргэдийг сэрэмжлүүлсэн ба шувууны томуу өвчний тандалтын судалгааг том нууруудын орчим жил бүр явуулж байна. Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг жил бүрийн төсөвт тусган, аймгийн Засаг даргаас сумын Засаг дарга нартай байгуулах гэрээнд нэг үзүүлэлт болгон оруулж, 2009 онд халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардалд 260,0 сая төгрөгийг тусгаж, сумдын ЗДТГ-аар дамжуулан санхүүжүүлсэн.

Хэрэгжих шатандаа-50%

2.3.12.6. "Мал эмнэлэг, үржлийн анхан шатны үйлчилгээний нэгжийг дэмжих хөтөлбөр" боловсруулан хэрэгжүүлж, сум дүүргийн мал эмнэлэг, үржлийн анхан шатны нэгжүүдийг бэхжүүлнэ.

Биелэлт- Тус аймагт байгаа мал эмнэлгийн 64 нэгжид аттестатчилал явуулж 2 нэгжийн лицензийг хүчингүй болгосон. Хувийн мал эмнэлгийн байрны зураг төсөв гаргуулан түүний дагуу байр барих шаардлага тавьж байна.

Хэрэгжих шатандаа-30%

2.3.13.3. 4000 худаг шинээр гаргаж, 1000 худаг сэргээн засварлахад дэмжлэг үзүүлнэ.

Биелэлт- 2009 онд Улсын төсвийн 87,0 сая төгрөгийн хөрөнгөөр инженерийн хийцтэй 6 худаг шинээр гаргах тендер зарлан зохих хууль, тогтоомжийн дагуу мэргэжлийн байгууллагыг шалгаруулан гэрээ байгуулж, ажлаа гүйцэтгэж ашиглалтад оруулсан. Мөн өвөлжилтийн байдалтай холбогдуулан 2 худаг шинээр гарган, 1 худгийг сэргээн засварлаж ашиглалтанд оруулсан.

Хэрэгжих шатандаа-70%

2.3.13.4. Газрын доорхи усны геофизикийн хайгуул хийж 1600 уст цэгийг шинээр тогтооход дэмжлэг үзүүлнэ.

Биелэлт- Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг 2007, 2008 онд шинээр гаргасан болон сэргээн засварласан худаг уст цэгийн тооллогыг бүрэн хийж дууссан. Шинээр худаг гаргах болон сэргээн засварлахад зохих журмын дагуу тендер зарлан мэргэжлийн байгууллагыг шалгаруулан гүйцэтгэж байна.

Хэрэгжих шатандаа-30%

2.3.13.5. Жил бүр 100.0 мянган га-д царцаатай, 500-гаас доошгүй мянган га-д мэрэгчтэй тэмцэх ажлыг гүйцэтгэж мал аж ахуйн үйлдвэрлэлд ашиглах бэлчээрийг нэмэгдүүлнэ.

Биелэлт- Царцааны тархалтыг биологийн зохистой хугацаанд судлах талаар ХХААХҮЯаманд асуудал тавьж биологийн хүрээлэнгээс мэргэжлийн хүн ирүүлж судалгаа хийлгэн 2008 онд 20,0 мянган га 2009 онд 6 суманд 4 тн хор зарцуулж 30,0 га-д царцаатай тэмцэх арга хэмжээг графикт хугацаанд зохион байгуулсан.

Хэрэгжих шатандаа-50%

2.3.13.6. Газрын төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах талаар хуулийн төсөл боловсруулна.

Хуулийн төсөл батлагдаагүй-0

2.3.14.1. "Хоршоог дэмжих хөтөлбөр" хэрэгжүүлж, мал борлуулах, түүхий эд бэлтгэх чиглэлээр сум, дүүрэг, тосгодод иргэдийн хоршоо, нөхөрлөл байгуулахад дэмжлэг үзүүлнэ.

Биелэлт- "Хоршоог хөгжүүлэх дэд хөтөлбөр-2"-ыг аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн хуралдаанаар оруулж, 153 дугаар тогтоолоор батлуулсан. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээнд 2010 онд төсөвт тусгуулахаар 12,5 сая төгрөг төлөвлөж оруулсан боловч, төсвийн боломжгүйгээс батлагдаагүй. Харин ЖДҮ-г хөгжүүлэх зорилгоор зээл олголтыг салбараар нь авч үзвэл хүнсний үйлдвэрийн 8 буюу 8,3 хувь, ХАА 42 буюу 50,6 хувь, Хөнгөн үйлдвэрийн 5 буюу 6 хувь, Барилгын материалын 12 буюу 14,3 хувь, эм бэлдмэлийн 1 буюу 1,2 хувь, ахуйн үйлчилгээний 8 буюу 9,6 хувь, худалдаа үйлчилгээний 7 буюу 8,4 хувийг тус тус олгогдсон байгаа боловч сумдад олгогдох ёстой 50 сая төгрөгний хөрөнгө оруулалт шийдвэрлэгдэхгүй байгаа нь хөдөө орон нутагт ЖДҮ-г хөгжүүлэх боломж муутай байна.

Хэрэгжих шатандаа-50%

2.3.16.1. "Мал сүргийг зарим зооноз халдварт өвчнөөс эрүүлжүүлэх хөтөлбөр" боловсруулан хэрэгжүүлж, өрх, баг, сум, дүүрэг, аймгийн түвшинд эрүүлжилтийг баталгаажуулан гэрчилгээжүүлэх арга хэмжээ авна.

Хэрэгжээгүй-0

2.3.17.1. Байгаль экологид сөрөг нөлөөгүй дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх замаар өнжөөсөн болон атаршсан талбайг эргэлтэд оруулна.

Хэрэгжилт-0

2.3.17.2. Тэг болон цомхотгосон аргаар бэлтгэх уриншийн хэмжээг 50,0 мянган га талбайд хүргэнэ.

Хэрэгжилт-0

2.3.18.1. Зоорь, агуулахын төрөлжсөн аж ахуй байгуулахад дэмжлэг үзүүлэн, томоохон хотуудад хүнсний нарийн ногооны төрөлжсөн бөөний худалдааны зах, биржийн тогтолцоо бүрдүүлнэ.

Хэрэгжилт -0

2.4. Дэд бүтэц, хот байгуулалтын бодлого

2.4.5.2. Монгол улсын иргэн бүрт үнэгүй өмчлүүлэх боломжтой газрын хэмжээ, байршил, зориулалтыг тогтоож, газар өмчлүүлэх ажлыг зохион байгуулна.

Биелэлт- Аймгийн хэмжээнд 26,245 га газрыг 259 иргэний өмчлөлд олгоод байна. Жил бүр аймгийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг ИТХ-ын хуралдаанаар батлуулж мөрдөн ажиллаж байна.

Хэрэгжих шатандаа-30%

2.4.5.3. Нийслэлийг аймгийн төвүүдтэй холбосон улсын чанартай авто замын дагуу иргэдэд өмчлүүлэх боломжтой газрын хэмжээ, байршил, зориулалтыг тогтоож, өмчлүүлэх ажлыг зохион байгуулна.

Биелэлт- 2009 онд Өлгий-Цагааннуурын хатуу хучилттай 30 км замыг үргэлжлүүлэн барих 13 тэрбум төгрөгийн хөрөнгийг шийдвэрлүүлж, гүйцэтгэгчийг нь тодруулан газар шорооны ажлыг эхлүүлснээр энэ замыг 2011 онд багтаан дуусгах боломжтой боллоо. Баруун бүсийн автозамыг хөгжүүлэх төслийн хүрээнд Өлгий-Хашаатын чиглэлийн хатуу хучилттай автозамыг БНХАУ-ын 50,0 сая ам долларын хөнгөлөлттэй зээлээр 2010 оны эхний улирлаас эхлэн барихаар эцэслэн шийдвэрлэсэн. Одоогоор улсын чанартай томоохон зам барих ажил эхлэлтийн чанартай байгаа учир ийм замын дагуу газар өмчлүүлэх асуудал судалгааны шатанд байна.

Хэрэгжих шатандаа-10%

2.4.5.4. Аж ахуйн болон гэр бүлийн хэрэгцээнд зориулан өмчлүүлэх газар тариалангийн болон эрчимжсэн фермерийн аж ахуйн нэгжийн зориулалтын газрын хэмжээ, байршлыг тогтоон, өмчлүүлэх ажлыг зохион байгуулна.

Биелэлт- Өлгий хотын 9,6-р багийн нутаг дэвсгэр дэх сул чөлөөлтэй газрыг гэр бүлийн хэрэгцээнд болон ногоон бүс байгуулах зориулалтаар олгож эхэлсэн. Ногооннуур, Алтанцөгц, Баяннуур сумын нутагт усалгаатай газар тариалан эрхлэх зориулалтаар газар олгож байна.

Хэрэгжих шатандаа-30%

2.4.6.5. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хилийн цэсийг эргэлтийн цэгийн солбицлуудаар тодорхойлон баталгаажуулах ажлыг шат дараатай хийж, солбицлын нэгдсэн тогтолцоонд шилжүүлнэ.

Хэрэгжээгүй-0

2.4.7.1. Шинэ хотхон, хорооллыг барих ажлын хүрээнд 37,0 мянган орон сууц барина.

Биелэлт- 40 айлын орон сууц ашиглалтад бүрэн орсон. 20 айлын орон сууцны барилгын угсралтын ажлын 4 давхарын угсралтыг бүрэн дуусгасан. 5 давхарын ханын өрлөгийн хучилтаас бусад ажлыг 2010 онд дуусган ашиглалтад оруулна.

Хэрэгжих шатандаа-30%

2.4.11.1. Баруун, Хангайн, Төвийн, Зүүн болон Говийн бүсийн хөгжлийн хөтөлбөрийг боловсруулна.

Биелэлт- Баруун бүсийн хөгжлийн хөтөлбөр боловсруулж, батлуулсан. Хэрэгжих шатандаа байна.

Хэрэгжих шатандаа-50%

2.5. Орон нутгийн хөгжлийн бодлого

2.5.2.2. Баг бүрийг өрхийн амьжиргааг дэмжих, ядуурлыг бууруулахад чиглэгдсэн 1,0 саяас доошгүй төгрөгийн эх үүсвэртэй, эргэн төлөгдөх нөхцөл бүхий хөгжлийн сантай болгоно.

хэрэгжилт-0%

2.5.3.6. Аймгийн төвүүдийн дулаан хангамжийн байдалд судалгаа хийж, шинэчлэлтийн техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулна.

Биелэлт- Өлгий хотын дулаан хангамжийн тооцоо судалгаа хийж, дулааны үйлдвэрийн тогоо, газар доорх шугам сүлжээг шинэчлэх ажлыг үе шаттай хийж эхэлсэн.

Хэрэгжих шатандаа-30%

2.5.3.7. Аймгийн төвийн дулааны станц, дулаан хангамжийн системийн харьялал, өмчийн хэлбэр, шугам сүлжээний хил заагийг тогтоож, дулаан хангамжийн зуух, тоног төхөөрөмжийг үе шаттайгаар шинэчлэх, халаалтын доголдлыг бүрэн арилгаж, хэрэгцээний халуун усны системтэй болгон ард иргэдийн амьжиргааны таатай нөхцөлийг бүрдүүлнэ.

Биелэлт- КЕ уурын тогоонуудыг бүхэлд нь усан халаалтад шилжүүлж, нэг зуухны ширэм, 80 метр нүүрс дамжуулах лент, филтер шүүгч, зуух болон ДШС-ний хэсэгт нийт 1650 метр хоолойг шинээр хийсэн. Өлгий хотын ДШС-д гидравалкийн горимын тооцоо хийлгэж 212 ширхэг шайба сольж тавьснаар халаалт эрс сайжирсан. Уурын тогоонуудыг бүрэн усан халаагуурт шилжүүлсэн. Толбо сумын төвийн халуун ус болон Алтай сумын ахлах сургуулийн халуун усанд засвар хийгдсэн. Улаанхус сумын төвд халуун усны шинэчлэлт хийсэн.

Хэрэгжих шатандаа-50%

2.5.4.1. Улсын төсөв, Монгол Улсыг хөгжүүлэх сан болон дотоод, гадаадын хөрөнгө оруулалтаар цахилгаан дамжуулах, түгээх сүлжээний өргөтгөл, засвар, шинэчлэлийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

Биелэлт- Тус аймгийн Булган сумыг Ховд аймгийн Дуутаас ЦДАШ-аар холбох ажлыг 2010 онд дуусгана.

Хэрэгжих шатандаа-30%

2.5.6.3. Орон нутгийн эрдэс, түүхий эдийн нөөцөд тулгуурлан бүс нутгуудад бетон, төмөр бетон, дуу чимээ, дулаан тусгаарлах болон ханын материалын үйлдвэрлэлийг хөгжүүлэх асуудлыг шийдвэрлэнэ.

Хэрэгжилт-0

2.5.7.2. Алслагдсан болон говийн бүсийн байгалийн хүнд нөхцөлд амьдарч, ажиллаж байгаа иргэдэд нийгмийн хөнгөлөлттэй үйлчилгээ үзүүлэх асуудлыг судалж шийдвэрлэнэ.

Хэрэгжээгүй-0

2.5.9.1. Сургуулийн дотуур байр, эмнэлэг, соёлын төвийг шинээр барих буюу өргөтгөж засварлах арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлнэ.

Биелэлт- Цэнгэл, Дэлүүн сумдын ахлах сургуулиудын дотуур байранд их засвар, Алтай, Сагсай сумын ахлах сургуулийн өргөтгөл хийж, Баяннуур, Сагсай, Цэнгэл сумын сургуулийн дотуур байрны үйлчилгээг сайжруулах арга хэмжээ авсан. Улаанхус сумын Хөх-хөтөл багт дотуур байрны зураг төсөв хийгдэж, хэрэгжих шатандаа байна. Сумдын төрийн үйлчилгээний байгууллагуудын барилгуудад дэс дараатай засвар хийгдэж байна. Баяннуур, Алтай, Булган, Ногооннуур сумын хүн эмнэлгийн барилгын техникийн нөхцөл болон зураг төслийн ажил хийгдсэн ба холбогдох дээд шатны газарт хүргүүлж, 2010 онд шинээр барихаар төсөвт тусгуулав. Буянт сумд шинээр соёлын төв барих зураг төслийн ажил бүрэн хийгдсэн ба хөрөнгийн асуудлыг 2010 багтаан шийдвэрлэхээр болсон.

Хэрэгжих шатандаа-30%

2.5.10.1. "Атрын 3 дахь аян" тариалангийн хөгжлийн үндэсний хөтөлбөрийн хүрээнд газар тариалангийн техник, технологийн парк шинэчлэх ажлыг хэрэгжүүлж өндөр хүчин чадалтай трактор 725, үр тарианы комбайн 550-ийг нийлүүлнэ.

Биелэлт- ДЗОУ-ын байгууллагаас малчдын амьжиргааг дээшлүүлэх төслийн хүрээнд бага оврын 9 трактор, агропарк, бэлчээр хамгаалах чиглэлээр 14 тракторыг дагалдах хэрэгслийн хамт ААН, байгууллагуудад үнэ төлбөргүй өгсөн. Мөн сумын тухайн жилийн төлөвлөгөөнд тусгасан зарим томоохон арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх зорилгоор ТА-2 төслөөс 5000 ам долларын санхүүжилт олгогдохоор болоод байна. Газар тариалан эрхэлдэг, тэжээл бэлтгэдэг аж ахуйн нэгжүүдэд сүүлийн 2 жилд 18 ширхэг бага оврын трактор дагалдах хэрэгслийн хамт 50 хувийн хөнгөлөлттэй үнээр олгосон.

Хэрэгжих шатандаа-30%

ГУРАВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ ТЭНЦВЭРТ ХАРЬЦААГ ХАНГАХ ЗОРИЛТ

3.2.1. Агаарын бохирдлыг бууруулах, чанарыг хангах эрх зүйн орчныг шинэчилж, агаарын бохирдлыг бууруулах талаар хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.

Хэрэгжээгүй-0

3.2.4. Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанаас агаарт гаргах тоосонцрын хаягдлыг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Биелэлт- Манай аймгийн хувьд одоогоор агаарт гарах тоосонцрын хог хаягдал байхгүй.

Хэрэгжилт -0%

3.3.2. Томоохон хот суурин газрын цэвэрлэх байгууламжид техник, технологийн шинэчлэл хийж, ашиглалтыг сайжруулан, стандартын шаардлага хангуулна.

Биелэлт- Гадаад орнуудаас дэвшилтэт технологитой автомат ажиллагаатай насосны станц, цэвэр бохир усны лаборатори мөн моноблок цэвэрлэх байгууламжуудийг хандив тусламжаар авах саналыг боловсруулан холбогдох газруудад хүргүүлсэн. Цэвэрлэх байгууламжийн байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэсэн ба цэвэрлэх байгууламжийн биологийн цөөрөмд худаг гарган дээж авч газрын гүний усан дахь нөлөөллийг лабораторит байнга шинжилж байна. Цэвэрлэх байгууламжийн ирж буй усны шинжилгээг байнга хийж байгаа ба одоогоор биологийн цөөрөмүүдээс хальж голд цутгаж байгаа ус үгүй байна.

Хэрэгжих шатандаа-50%

3.4.2. Бүх аймгуудын хатуу хог хаягдлын мастер төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлнэ.

Биелэлт- Хог хаягдлын мастер төлөвлөгөө боловсруулан түүний дагуу үйл ажиллагаа явуулж байна.

Хэрэгжих шатандаа-30%

3.4.4. Бүсийн тулгуур төв хотуудад хог хаягдал дахин боловсруулах үйлдвэр байгуулах, томоохон хот, суурин газрын хог хаягдлын төвлөрсөн цэгийг тохижуулж, хог хаягдлыг булшлах ландшафллийн аргыг нэвтрүүлнэ.

Биелэлт- Аймгийн төвд ОО-ийн цаасны үйлдвэр байгуулагдан хаягдал цаасаар ариун цэврийн цаас үйлдвэрлэж байна. Хог хаягдлын төвлөрсөн цэгийн хог хаягдлыг булшлах ландшафллийн аргыг хэрэгжүүлж байна.

Хэрэгжих шатандаа-50%

3.5.2. Гол, мөрний сав газрын зөвлөлүүдийг байгуулан ажиллуулж, сав газрын усны менежментийн төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлнэ.

Биелэлт- Ховд, Сагсай голын сав газрын зөвлөлүүдийг байгуулан ажиллуулж сав газрын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөг боловсруулж байна.

Хэрэгжих шатандаа-10%

3.5.10. Усан сан бүхий газар, ус хангамжийн эх үүсвэрийн хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийг шинэчлэн тогтоож, дэглэмийг мөрдүүлнэ.

Биелэлт- Усан хангамжийн онцгой, энгийн болон эрүүл ахуйн хамгаалалтын бүсийг шинэчлэн тогтоож дэглэмийг мөрдүүлэн ажиллаж байна.

Хэрэгжих шатандаа-30%

3.6.1. Гадаргуугийн ургац, хур тунадасны усыг хуримтлуулах замаар усан сан болон хөв, цөөрөм байгуулж бэлчээр, хадлан, тариалангийн талбайг усжуулах, ногоон байгууламжийн усалгаанд ашиглах аж ахуйн нэгж, иргэдийн үйл ажиллагааг дэмжинэ.

Биелэлт- Хур тунадасны усыг хуримтлуулах усан сан, хөв цөөрөм бүхий услалтын систем 2-ыг байгуулан хадлан тариалангийн талбай ургацыг нэмэгдүүлэх арга хэмжээ авч ажиллаж байна.

Хэрэгжих шатандаа-30%

3.6.2. Ойжуулах, мод, бут, сөөг, загийг үрээр тарималжуулах, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор иргэд, аж ахуйн нэгжийн төсөл, арга хэмжээг санхүүгийн болон бусад хэлбэрээр дэмжинэ.

Биелэлт- Нутгийн байгаль цаг уурын нөхцөлд зохицсон үрээр тарималжуулах зорилгоор Өлгий сумын хар үзүүр гэдэг газарт 40га мод үржүүлэгийн талбайд 2009 онд 1300 харгана, 1200ширхэг бургас улиас, 1200 цагаан харгана, 70,0 мянган жижиг мөчир тарьж арчлан ургуулж иргэд, аж ахуйн нэгж байгууллагыг үрээр хангаж байна.

Хэрэгжих шатандаа-30%

3.7.1. Бэлчээрийн тогтвортой менежментийг хэрэгжүүлэн, говь, хээрийн бүсийн усны нөөцийн судалгааг явуулж, уст цэг гаргах дүгнэлт гарган баг бүрт нар, салхины эрчим хүчээр ажиллах тус бүр нэг худаг гаргана.

Хэрэгжилт-0

3.9.1. "Атрын 3 дахь аян"-ыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд ойн зурвас бүхий тариалан эрхлэлтийг урамшуулах, дэмжих бодлого хэрэгжүүлнэ.

Хэрэгжилт-0

3.14.2. Орон нутгаас тусгай хамгаалалтад авах газар нутгийн шалгуур үзүүлэлт, үндэслэлийг шинэчлэн тогтоож, бүртгэл тооцоог Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн нэгдсэн сүлжээнд хамруулна.

Биелэлт- Шинээр нэмж Улсын тусгай хамгаалалтанд авах газар нутгийн судалгааг хийж байна.

Хэрэгжих шатандаа-10%

3.14.8. Тусгай хамгаалалттай газар нутгийн байгаль орчны төлөв байдалд үнэлгээ хийж, дүгнэлт гарган тухайн газрын онцлог, нөөц даацад тохируулан аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулах арга зүйг боловсруулан мөрдүүлнэ.

Биелэлт- ТХГН-ийн байгаль орчны төлөв байдалд үнэлгээ хийж дүгнэлт гарган нөөц даацад тохируулан аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулж байна. Алтай таван богд, Цамбагарав, Цагаан гол, Даян Сыргалийн чиглэлд нүүдлийн жуулчны бааз ажиллуулдаг болсон.

Хэрэгжих шатандаа-30%

3.15.4. Нэн тэргүүнд ойжуулах, нөхөн сэргээх шаардлагатай газрыг тодорхойлж, нийтэд зарлан, жилд 10,0 мянган га-аас доошгүй талбайг ойжуулж, нөхөн сэргээнэ.

Биелэлт- 2009 онд 165 га газарт ойжуулалт хийсэн болно. "Шар нуур ногоон бүс", "Онгоцны буудал ногоон бүс" томоохон төсөл боловсруулж, хөрөнгийн эх үүсвэрийг хайж байна.

Хэрэгжих шатандаа-30%

3.15.9. Хууль бусаар мод бэлтгэхтэй тэмцэх, хянах үйл ажиллагааг орчин үеийн технологи ашиглан боловсронгуй болгож, орон нутгийн ойн байгууллага болон нутгийн иргэдийн оролцоог түшиглэн тэмцэнэ.

Биелэлт- ТХГН-ийн болон БОАЖГ-ын байгаль хамгаалагчдыг унаа хөсөг, холбооны хэрэгслээр хангаж, орон нутгийн иргэд нөхөрлөлтэй хамтран хууль бусаар мод бэлтгэхтэй тэмцэн ажиллаж байна.

Хэрэгжих шатандаа-30%

3.16.4. Ховордсон амьтныг хамгаалах ажлыг сайжруулж, мазаалай баавгай, хавтгай тэмээ, баданга хүдэр, монгол бөхөн, буган цаа, голын халиу, хар мөрний хилим зэрэг нэн ховор амьтдыг идээшил нутагт нь өсгөн үржүүлэх, тэдгээрийн генийн санг хамгаалахад биотехнологийн ололтыг ашиглана.

Биелэлт- Тус аймгийн Буянт сумын нутагт шинээр нутагшин өсөж үржиж байгаа аргалийн сүрэгт өвс тэжээл, хужир шүү тавьж өгдөг болсон.

Хэрэгжих шатандаа-10%

3.17.3. Газрын нэгдмэл сангийн тайлангийн өгөгдлүүдийг боловсронгуй болгох, түүнд газрын ангиллын шилжилт, хөдөлгөөнийг байнга тусгах, байгаль орчны даац, чадавхид нийцүүлэн газар зохион байгуулалтын урт хугацааны менежментийн төлөвлөгөөг болосруулж хэрэгжүүлнэ.

Биелэлт- Аймгийн ГХБХБГ-аас газар зохион байгуулалтын стратеги төлөвлөгөөг боловсруулан мөрдөж ажиллаж байна. Жил бүр газрын сангийн тайлан, газар зохион байгуулалтын төлөвлөгөөг ИТХ-аар батлуулж, хэрэгжилтэд нь хяналт тавьж байна.

Хэрэгжих шатандаа-30%

3.17.5. Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөгөөр дамжуулан байгаль орчныг хамгаалах, нөөцийг зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлнэ.

Биелэлт- Аймгийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд байгаль хамгаалах, нөөцийг зохистой ашиглах, нөхөн сэргээх талаар тусган ажиллаж байна.

Хэрэгжих шатандаа-10%

3.18.2. "Аялал жуулчлалын үндэсний хөтөлбөр" боловсруулж хэрэгжүүлнэ.

Хэрэгжээгүй-0%

3.18.3. "Аялал жуулчлалын маркетингийн стратеги төлөвлөгөө" боловсруулж, Монгол Улсыг нэгдсэн бодлоготойгоор гадаадад сурталчлах ажлыг зохион байгуулна.

Хэрэгжээгүй-0%

3.18.4. Аялал жуулчлалын мэдээллийн сан бий болгож, салбарын статистик бүртгэлийг сайжруулна.

Биелэлт- Аймгийн аялал жуулчлалын мэдээллийн сан байгуулан салбарын статистик бүртгэлийг сайжруулсан.

Хэрэгжих шатандаа-30%

3.18.5. Жуулчин тээвэрлэх, хүлээн авах хүчин чадлыг нэмэгдүүлэн, салбарын хүний нөөцийг хөгжүүлэх, чадавхийг дээшлүүлэх арга хэмжээг хэрэгжүүлж, аялал жуулчлалын үйлчилгээний чанарыг олон улсын жишигт ойртуулна.

Биелэлт- Монгол Алтайн нурууны УТХгазар, аймгийн БОАЖгазар 2009 онд тус бүр аялал жуулчлал хариуцсан мэргэжлийн боловсон хүчин авч ажиллуулж байна.

Хэрэгжих шатандаа-30%

3.18.6. Аялал жуулчлалын томоохон цогцолбор барьж байгуулна.

Хэрэгжээгүй-0%

3.18.7. Түүх, соёлын болон адал явдалт, тусгай сонирхлын аялал жуулчлалыг түлхүү хөгжүүлж, аялал жуулчлалын эвент, арга хэмжээнүүдийг зохион байгуулах ажлыг дэмжинэ.

Биелэлт- Сүүлийн жилүүдэд түүх соёлын болон тусгай сонирхлын аялал хийхээр судлаач эрдэмтэд цөөнгүй ирж аялаж байгаа. Энэ чиглэлээр судалгааны материал, ном хэвлэл, аяллын маршрут гаргаж сурталчилж байна.

Хэрэгжих шатандаа-30%

3.19.2. Байгалийн нөөц баялгийг хамгаалах, зохистой ашиглахтай холбогдуулан аймаг, сумын Засаг даргын үүрэг, хариуцлагыг өндөржүүлнэ.

Биелэлт- Аймгийн Засаг даргын захирамжаар 2009 онд Алтай Соёоны биологийн төрөл зүйлийг хамгаалах төсөл хэрэгжиж буй 6 сумдад байгаль орчны хэсэг байгуулан байгаль хамгаалах, нөөц баялагийг зохистой ашиглах чиглэлээр байгаль орчны чиглэлийн байгууллагууд ард иргэд хамтран үйл ажиллагаа явуулж байна.

Хэрэгжих шатандаа-30%

3.19.3. Ашиглт малтмал олборлосон эдэлбэр газрыг нөхөн сэргээх стандартыг баримтлан хяналт, хариуцлагын механизмыг боловсронгуй болгоно.

Биелэлт- Ногооннуур, Цэнгэл, Алтанцөгц суманд ашигт малтмал олборлосон эдэлбэр газарт техникийн нөхөн сэргээлт хийгдэж байна.

Хэрэгжих шатандаа-30%

3.19.4. Байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлж байгаа үйлдвэр, үйлчилгээнд тавих байгаль орчны болон олон нийтийн хяналтыг сайжруулна.

Биелэлт- Байгаль орчны байгууллага олон нийт ард иргэдтэй хамтран хяналт тавьж ажиллаж байна. Сум баг бүрт байгаль орчин хамгаалах сайн дурын идэвхтнүүдийн бүлэг ажиллуулдаг болсон.

Хэрэгжих шатандаа-30%

ДӨРӨВ. ЭРХ ЗҮЙТ ТӨРИЙГ ТӨЛӨВШҮҮЛЖ, ЗАСАГЛАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ИЛ ТОД, НЭЭЛТТЭЙ БОЛГОХ ЗОРИЛТ

4.1. Эрх зүйн бодлого

4.1.3.2. Эрх зүйн хэм хэмжээ тогтоосон захиргааны актыг нийтэлдэг “Хууль зүйн мэдээлэл” сэтгүүлийг аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газраар дамжуулан засаг захиргааны анхан, дунд шатны нэгж, байгууллага бүрт хүргэх арга хэмжээ авна.

Биелэлт- Төрийн мэдээлэл сэтгүүлийг бүх сум албан байгууллага бүр захиалан хууль тогтоомжийн мэдээлэл лавлагааны сан бүрдүүлэн ашиглаж байна. Аймгийн ЗДТГ-ын Хууль зүйн хэлтсийн хууль тогтоомжийн бүртгэл лавламжийн санд нийт 6342 эрх зүйн акт бүртгэлтэй байна. Энэ санд 2009 оны эхний 11 сард нийт 377 эрх зүйн акт шинээр нэмж бүртгэсэн. Үүнээс хууль 161, УИХ-ын тогтоол 61, Засгийн газрын тогтоол 129, Ерөнхийлөгчийн хэм хэмжээ тогтоосон зарлиг 3, ҮХЦ-ийн дүгнэлт 7, УДШ-ийн тогтоол 17, яам агентлагийн акт 54 байна. Бүгд 161 эрх зүйн актын 561 зүйл, заалт, хэсэгт нэмэлт өөрчлөлтийн хөдөлгөөн хийсэн. Үүнд 120 хуулийн 520 зүйл заалт хэсэг болон Засгийн газрын 41 тогтоолд хөдөлгөөн хийгдэв. Засгийн газрын 64 тогтоол болон 27 хуулийн 98 зүйл заалтыг хүчингүй болгосныг бүртгэж хөдөлгөөн хийв.

Хэрэгжих шатандаа-30%

4.1.3.5. “Эрх зүйн туслалцааны төв”-ийг 21 аймаг, 9 дүүрэгт НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн туслалцаатайгаар байгуулж, үйлчилгээний хүрээг өргөжүүлнэ.

Биелэлт- Тус аймгийн эрх зүйн туслалцааны төв байнгын ажиллаж байгаа бөгөөд 2009 онд тус төвөөр төлбөрийн чадваргүй 1100 хүн үйлчлүүлж эрх зүйн зөвлөгөө, 132 иргэн эрх зүйн актаар лавлагаа авсан. Тус төвөөс эрх зүйн албан бус сургалтыг 9 удаа 16 сэдвээр хийж 156 хүн хамрагдлаа. 698 хүний 4689 хуудас баримт бичгийг олшруулж өгсөн.

Хэрэгжих шатандаа-50%

4.2. Гэмт хэрэгтэй тэмцэх

4.2.10.3. Согтууруулах ундааны үйлдвэрлэл, үйлчилгээний цэгүүдийн үйл ажиллагаанд мэргэжлийн байгууллагуудтай хамтран үзлэг шалгалт тогтмол явуулж, гаргасан санал, дүгнэлтийг үндэслэн холбогдох арга хэмжээ авна.

Биелэлт- Аймгийн МХГ, Цагдаагийн хэлтэс, Татварын хэлтэс, Гаалийн газар, Өлгий сумын ЗДТГ, Хил, Тагнуулын газартай хамтарч тусгай төлөвлөгөө гаргаж нийт 48 удаа нэгдсэн шалгалт хийж илэрсэн зөрчил дутагдлуудыг тухайн үед арилгуулах арга хэмжээ авч ажиллав. Одоо аймгийн төвд үйл ажиллагаа явуулж байгаа 138 мухлаг, хүнсний дэлгүүрээс 124 согтууруулах ундаа худалдах, 15 баар, зоогийн газрууд тусгай зөвшөөрөлтэй ажиллаж байна. Одоогийн байдлаар нормативын тоо хэтэрсэн байгаа ба нэмж олгоогүй болно. 2009 онд тус аймагт гэмт хэргийн тоо 2008 оныхоос 30%-иар буурсан.

Хэрэгжих шатандаа-50%

4.2.12.3. Ялтны мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв байгуулж, ялтныг байнгын ажлын байраар хангах асуудлыг шийдвэрлэнэ.

Биелэлт- Тус аймгийн хувьд хорих ял эдлүүлэх анги байдаггүй, харин аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанд 5 ялтанг захиалгаар авч ажиллуулж байгаа.

Хэрэгжилт-0

4.3. Хил хамгаалах бодлого

4.3.3.1. Улсын хил хамгаалах үүргийн 50 хүртэлх хувийг гэрээт хилчнээр гүйцэтгүүлэх арга хэмжээ авна.

Биелэлт- Тус аймгийн нутаг дэвсгэрээр хиллэдэг ОХУ болон БНХАУ-ын хилийн хамгаалалтыг хилийн цэргийн 0165, 0285 дугаар ангиуд амжилттай гүйцэтгэж байна. Хил зөрчсөн болон хилийн дэглэм зөрчсөн ноцтой зөрчил гараагүй. Харин бэлчээрээр хил давсан малаа буцаан авах, төөрөх байдлаар хил зөрчих тохиолдол гарч байгааг анхааран ажиллаж байна. өмнөх жилүүдтэй харьцуулахад хил орчмоор мал хулгайлж хил давуулах гэмт хэрэг эрс буурсан болно.

Хэрэгжих шатандаа-30%

4.5. Иргэний нийгэм, төрийн удирдлагын бодлого

4.5.4.3. Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд тавигдах тусгай шаардлагад нийцүүлэн төрийн захиргааны болон хуульд өөрөөр заагаагүй бол төрийн тусгай албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг нээлттэй өрсөлдөөний зарчмаар сонгон шалгаруулах журмыг шинэчлэн боловсруулна.

Биелэлт- Монгол Улсын Төрийн албаны Зөвлөлөөс шинээр батлан гаргасан заавар журмыг баримтлан ажиллаж байна. Төрийн захиргааны сул орон тоо гарсан тохиолдолд нээлттэй өрсөлдөөний зарчмаар сонгон шалгаруулдаг журам бүрэн хэвшсэн.

Хэрэгжих шатандаа-30%

4.5.4.4. Төсвийн байгууллагын ерөнхий менежерүүдийг манлайлах ур чадвар дээшлүүлэх сургалтын хөтөлбөрт хамруулан сургаж, чадавхийг бэхжүүлнэ.

Биелэлт- 2009 онд удирдах ажилтан албан тушаалтан болон ажилтан давхардсан тоогоор нийт 80 хүнийг сургалтанд хамруулсан. 2009 онд 6 агентлагийн дарга, 2 сумын ЗДТГ-ын дарга, 4 ахлах сургуулийн захирлын албан тушаалд сонгон шалгаруулалт хийсэн. 2009 онд нийт сумдын Засаг дарга, ИТХ-ын дарга, ЗДТГ-ын дарга нарыг төвлөрсөн болон бүсчилсэн, орон нутгийн сургалтанд бүрэн хамруулсан.

Хэрэгжих шатандаа-30%

4.5.4.5. Төсвийн байгууллагын тогтолцоо, бүтцэд судалгаа хийсний үндсэн дээр тэдгээрийн үйл ажиллагааны уялдааг хангах, иргэдэд үзүүлэх төрийн суурь үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх чиглэлээр боловсронгуй болгох арга хэмжээ авна.

Биелэлт- Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлхийн тулд нээлттэй хаалганы өдөр зохион байгуулдаг болсны дээр нэг цэгийн үйлчилгээ нэвтрүүлж эхэлсэн. Төрийн үйлчилгээний байгууллагуудын тайланг иргэдээр хэлэлцүүлдэг журам тогтоосон.

Хэрэгжих шатандаа-30%

4.5.5.1. Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны бүх шатны байгууллагын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийг шинээр болон шинэчлэн баталж мөрдүүлэх замаар ажил, үүргийн давхардал, хийдлийг арилгах, төсвийн зардлыг хэмнэх арга хэмжээ авна.

Биелэлт- Засгийн газрын “Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтцийг шинэчлэн тогтоох тухай” тогтоолын дагуу Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагуудыг байгуулж, ЗДТГ-ын бүтцийг 41 хүний бүрэлдэхүүнтэй, 5 хэлтэс, 2 тасагтай зохион байгуулсан. Сумдын ЗДТГ-ын бүтцийг Засгийн газраас ирүүлсэн журмын дагуу тогтоож зохион байгуулсан.

Хэрэгжих шатандаа-50%

4.5.5.2. Төрийн албан тушаал (ажлын байр)-ын чиг үүргийн шинжилгээ үнэлгээ хийсний үндсэн дээр хүлээх үүрэг, хариуцлагыг нь тодорхой тусгасан ажлын байрны тодорхойлолтыг шинээр боловсруулан баталж мөрдүүлнэ.

Биелэлт- 2009 онд аймгийн хэмжээндэх нутгийн захиргааны болон төрийн үйлчилгээний байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, төрийн албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтыг шинэчилж, түүнд хариуцлага сахилга батыг сайжруулах асуудлыг тодорхой тусгаж, хүлээлгэх хариуцлагыг чангатгасан.

Хэрэгжих шатандаа-30%

4.5.5.3. Гадаад, дотоод орчны хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн төсвийн байгууллага бүрийг өөрчлөн хөгжүүлэх замаар байгууллагын шинэ соёлыг төлөвшүүлэх, төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, баталгааг хангах арга хэмжээ авна.

Биелэлт- Төсвийн байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд төрийн албан хаагчдын ажлын нөхцлийг сайжруулах асуудлыг тусгасан.

Хэрэгжих шатандаа-10%

4.5.5.4. Төрийн албан дахь авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх арга хэмжээг холбогдох эрх бүхий байгууллагатай хамтран хэрэгжүүлж, энэ чиглэлээр үйлчилж буй хууль тогтоомжийг боловсронгуй болгоно.

Биелэлт-Төрийн албан хаагчдын хөрөнгө оруулгын мэдүүлгийг авдаг болсон. ТАХ-ийн мэргэжлийн шалгалт авах, нөөц бүрдүүлэх, томилгоо хийх бүх шатны хяналтыг сайжруулсан.

Хэрэгжих шатандаа-50%

4.5.5.5. Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээний дүрмийг шинэчлэн боловсруулж батлан мөрдүүлнэ.

Биелэлт- Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийн төслийг бэлэн болгосон.

Хэрэгжих шатандаа-30%

4.5.5.6. Төрийн тусгай, төрийн үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээний дүрмийг холбогдох хууль тогтоомжийн дагуу шинээр болон шинэлэн боловсруулж батлан мөрдүүлнэ.

Биелэлт- Төрийн захиргааны төв байгууллагуудтай хамтран, төрийн тусгай, төрийн үйлчилгээний албан хаагчдын ёс зүйн дүрэм боловсруулан батлаж, мөрдөн ажиллаж байна.

Хэрэгжих шатандаа-30%

4.5.6.6. Яамдын болон аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын хяналт-шинжилгээ үнэлгээний ажилтнуудыг хяналт-шинжилгээ үнэлгээ өндөр хөгжсөн орнуудын туршлага судлуулах, энэ чиглэлээрх гадаад, дотоодын сургалтанд ээлж дараатай хамруулах замаар ажилтнуудыг чадваржуулж төрийн захиргааны байгууллагуудын хяналт-шинжилгээ, үнэлгээний онол, арга зүйн түвшинг дээшлүүлнэ.

Биелэлт- Аймгийн ЗДТГ-ын хяналт-шинжилгээ, үнэлгээний тасгийн ажилтнуудыг бүсийн болон төвлөрсөн сургалтанд хамруулсан.

Хэрэгжих шатандаа-50%

4.5.7.2. Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуульд орон нутгийн бие даасан байдлыг хангах чиглэлээр нэмэлт, өөрчлөлт оруулах санал боловсруулна.

Биелэлт- ТБУСТХуулинд оруулах нэмэлт өөрчлөлтийн талаар санал боловсруулж УИХ-д хүргүүлсэн.

Хэрэгжих шатандаа-10%

4.5.7.3. Орон нутгийн өмчийн үр өгөөжийг нэмэгдүүлэн нутгийн өмчийн тухай бие даасан хуультай болгож, эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.

Биелэлт- Орон нутгийн өмчид байгаа байшин барилга, өрөө тасалгаануудыг түрээслэн жил бүр 10,0 сая төгрөгийн нэмэгдэл орлого олж байна. Орон нутгийн өмчийн аж ахуйн болон үйлчилгээний байгууллагуудыг түрээсийн болон гүйцэтгэлийн гэрээгээр ажиллуулж байна.

Сүүлийн 2 жилд орон нутгийн өмчийн аж ахуйн нэгж байгууллагууд алдагдалгүй, ашигтай ажилладаг боллоо.

Хэрэгжих шатандаа-30%

4.5.7.4. Орон нутгийн бие даасан байдлыг хангахад чиглэгдсэн жишиг /загвар/ сум шалгаруулах болзлыг баталж хэрэгжүүлнэ.

Биелэлт– Загвар сум шалгаруулах болзлыг нийт сумдад хүргүүлсэн, семинар зөвлөлгөө өгсөн. Аймагтаа тэргүүний сум шалгаруулах болзол зарлаж хагас, бүтэн жилээр дүгнэдэг болсон.

Хэрэгжих шатандаа-10%

4.5.8.1. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Нийслэлийн эрх зүйн байдлын тухай болон Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг боловсруулж шийдвэрлүүлнэ.

Хэрэгжээгүй-0

4.5.10.1. Төрийн захиргааны төв, нутгийн захиргааны болон сонгосон зарим салбарын нийтлэг болон туслах чиг үүргийг хамарсан стратегийн чиг үүргийн шинжилгээг тусгай төлөвлөгөөний дагуу хийж, чиг үүргийн давхардлыг арилгах, зохион байгуулалтын бүтцийг боловсронгуй болгох, орон тоог цөөрүүлэх арга хэмжээ авна.

Биелэлт- Нутгийн захиргааны байгууллагын бүтэц зохион байгуулалт чиг үүргийн байдлыг судлан үзэж, хөдөлмөрийн дотоод журам, ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг шинэчилсэн.

Хэрэгжих шатандаа-30%

ТАВ. ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН ЗОРИЛТ

5.1. Гадаад бодлого

5.1.1.14. ОХУ, БНХАУ, АНУ, Канад, Япон, ХБНГУ, БНСУ, БНКаЗУ-тай аймаг, хотуудын шууд харилцааг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

Биелэлт- ОХУ, БНКаЗУ, БНХАУ-ын ШУӨЗОрны төр, засгийн газрын байгууллагуудтай урт хугацааны хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж байгаа. 2009 онд ОХУ-ын Барнаул хотод 15 багш, Казахстан улсад 10 багш, 5 эмч нар очиж мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдсан. Гурилын үйлдвэр байгуулах асуудлыг судалж, ОХУ болон Казахстан Улсад асуудал тавьж хөөцөлдөж байна. Судалгааны шатанд байна.

Хэрэгжих шатандаа-30%

5.1.4.6. Хил, бүс нутгийн хамтын ажиллагаа хөгжүүлэх таатай нөхцлийг хангах талаар холбогдох талуудтай ажиллана.

Биелэлт- 2009 онд ОХУ, БНХАУ-ын хил орчмын муж, районы удирдлага, хилийн цэрэг, гааль, бусад хяналтын байгууллагуудын нэгдсэн зөвлөлгөөнийг 2 удаа хийж хил орчмын худалдаа хамтын ажиллагааны гэрээг шинэчилсэн. Хилийн худалдааг хөнгөвчлөх талаар ахиц гарсан.

Хэрэгжих шатандаа-50%

5.2. Батлан хамгаалах бодлого

5.2.7.1. Дайчилгааны I, II зэргийн бэлтгэл үүрэгтний сургалтын чанар, оролцох бүрэлдэхүүнийг үе шаттайгаар нэмэгдүүлнэ.

Биелэлт- Дайчилгааны бэлтгэл нөөцийн 1 дүгээр зэргийн чухал мэргэжлийн бэлтгэл үүрэгтний сургалтыг Улаанхус, Цэнгэл, Сагсай сумдаас дайчлан татаж 7 хоног, Улаанхус сум дахь Зэвсэгт хүчний 116-р салбарын сургалтын материаллаг баазыг түшиглэн сургалт явуулж операторчин, химчин зэрэг мэргэжил эзэмшүүлсэн. Дайчилгааны бэлтгэл нөөцийн

бүрэлдэхүүнтэй сургалт явуулах “Сургалтын төв” байгуулах талаар анхааран ажиллаж аймгийн төвийн Хилийн цэргийн 0165-р анги, Зэвсэгт хүчний 116-р салбарын сургалтын материаллаг баазыг бэхжүүлэх талаар дэмжиж хамтран ажиллаж байна.

Хэрэгжих шатандаа-50%

5.3. Гамшгаас сэргийлэх, хор хөнөөлийг арилгах үндэсний чадавхи бэхжүүлэх бодлого

5.3.4.2. Төв, орон нутгийн мэргэжлийн хяналтын байгууллагын материаллаг бааз, хүний нөөцийн чадавхийг сайжруулж, нийгмийн асуудлыг шийдвэрлэх арга хэмжээ авна.

Биелэлт- 2009 оны хөрөнгө оруулалтаар байгууллагын доторх гуанзны зориулалттай заалыг 3 жижиг өрөө тасалгаа болгон өөрчлөн засаж, тохижуулан байцаагчдыг ажил үүргээ явуулах нөхцөл боломжоор хангаж өгсөн. 3.0 сая гаруй төгрөгийн хөрөнгө гаргаж лабораторийн өрөө тасалгаануудыг стандартын шаардлагын хэмжээнд тохируулан бүрэн засварласан ба урд онд Даянгийн боомтын дутуу баригдсан ажилчдын болон ажлын байрыг өөрийн хүчээр барьж ашиглалтад оруулсан. Мөн 2009 онд 5,134,0 мянган төгрөгөөр 3 компьютер, 2 принтер, зургийн аппарат, зөөврийн компьютер 2, канон зэрэг техник хэрэгсэл авч, бүх ажилчин, байцаагч нар компьютерээр хангагдсан. Мэргэжлийн хяналтын байгууллагын лабораторийн хучин чадлыг нэмэгдүүлэхэд онцгой анхаарч УМХГ-ын хөрөнгө оруулалтаар аймгийн нэгдсэн лаборатори, Цагааннуур боомтын химийн лабораторид 45 сая төгрөгийн үнэтэй шинжилгээний багаж тоног төхөөрөмжийг олгосон. Нийт 16 улсын байцаагчид Улаанбаатар хотод болон орон нутагт зохион байгуулагдсан мэргэжил дээшлүүлэх сургалтуудад хамрагдсан. Байгууллагын дэргэдэх цайны газар ажиллуулж байна.

Хэрэгжих шатандаа -70%

5.3.4.3. Хилийн боомтуудын мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн орон тоог нэмэгдүүлж, зайлшгүй шаардлагатай багаж, техник хэрэгслээр ханган, ажлын болон ахуйн байртай болгоно.

Биелэлт- Хилийн мэргэжлийн хяналтын хэлтэст хяналт шалгалтын 4 чиглэлээр Ургамал хамгаалал хорио цээрийн хяналтын 2 улсын байцаагч, Эрүүл ахуй халдвар судлалын хяналтын 1 улсын байцаагч, Мал эмнэлгийн хяналтын 2 улсын байцаагч, Стандарт чанарын хяналтын 2 улсын байцаагч, нэг лаборантуудыг тус тус нэмж ажилд шалгаруулж авсан. Цагааннуур боомтын цогцолборын барилгад Хөл хориот халдварт өвчин гарсан үед өвчний сэжигтэй хүнийг тусгаарлах өрөөг шинээр гаргаж, шаардлагатай эмнэлгийн багаж, тоног төхөөрөмжийн жагсаалтыг гарган ариутгал бодис, гарын авлага, материал, бусад холбогдох зүйлүүдийг авч тохижуулсан. Мөн Америкийн хөрөнгө оруулалтаар цацраг идэвхитэй бодисыг тодорхойлох багаж суурилуулан ашиглаж байна. Хүнсний бүтээгдэхүүний анхан шатны тандалт хийх 6 төрлийн аппаратаар хангасан.

Хэрэгжих шатандаа-70%

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийн товчоо

(2009 оны жилийн эцсийн байдлаар)

Зорилт		Хэрэгжүүлэх арга хэмжээ		Хэрэгжилтийн явц /Хувь/							
Д/д	Дугаар	Д/д	Дугаар	100	90	70	50	30	10	Тасарсан	Х/болоогүй
НЭГ. ХҮН АМ НИЙГМИЙН ЗОХИСТОЙ БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛСНЭЭР ИРГЭДИЙН АМЬДРАЛЫН ЧАНАРЫГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТ											
1	1.1.1	1	1				50				
		2	3								0
2	1.1.4	3	1								0
3	1.1.5	4	1								0
		5	2		90						
4	1.1.6	6	3					30			
5	1.1.7	7	5					30			
		8	6			70					
		9	7								0
		10	8					30			
6	1.1.9	11	1						10		
		12	4		90						
7	1.1.11	13	2					30			
8	1.1.13	14	2						10		
9	1.1.19	15	1					30			
		16	2					30			
		17	3				50				
10	1.1.20	18	3					30			
11	1.2.2	19	1				50				
		20	2				50				
		21	4					30			
		22	5				50				
12	1.2.3	23	5					30			
13	1.2.4	24	5					30			
		25	6			70					
14	1.2.5	26	1					30			
		27	2				50				
15	1.2.6	28	3					30			
16	1.2.7	29	1		90						
		30	2								0
17	1.2.9	31	1					30			
		32	3					30			
		33	4				50				
18	1.2.10	34	1								0

19	1.2.12	35	2			70					
20	1.2.14	36	3							0	
21	1.2.20	37	1					30			
22	1.2.25	38	1				50				
		39	3							0	
23	1.2.28	40	3					30			
24	1.3.1	41	2				50				
25	1.3.6	42	2							0	
26	1.3.7	43	1							0	
27	1.3.15	44	1				50				
28	1.4.1	45	1						10		
29	1.4.6	46	1					30			
30	1.4.11	47	2							0	
31	1.4.12	48	1							0	
		49	2							0	
		50	3						10		
		51	4						30		
32	1.4.15	52	1				50				
		53	2				50				
		54	3				50				
33	1.5.2	55	2							0	
34	1.5.6	56	3					30			
35	1.5.10	57	1				50				

**ХОЁР. ҮЙЛДВЭРЖҮҮЛЭЛТИЙН БОДЛОГО ХЭРЭГЖҮҮЛСНЭЭР ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ
ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ЗОРИЛТ**

36	2.1.1	58	1				50				
37	2.1.2	59	1					30			
		60	2				50				
		61	6						30		
38	2.1.10	62	1						10		
39	2.1.14	63	1						10		
40	2.1.27	64	3						10		
		65	4					30			
41	2.1.28	66	4						10		
42	2.2.5	67	1							0	
		68	2						10		
		69	3								0
		70	4						30		
43	2.2.6	71	1				50				
44	2.2.7	72	4					30			
		73	5				70				
45	2.2.28	74	1					30			
46	2.2.30	75	1								
47	2.3.1	76	2					30			
		77	3					30			
		78	4					30			
		79	5					50			
		80	6							10	
48	2.3.5	81	1				50				

		82	2						10		
		83	3						10		
		84	4				50				
		85	5								
49	2.3.6	86	1				50				
		87	2						10		
		88	3					30			
		89	4								
50	2.3.7	90	1					30			
		91	2					30			
		92	3								0
51	2.3.8	93	1						10		
		94	2					30			
52	2.3.10	95	1					30			
		96	2					30			
53	2.3.11	97	3					30			
54	2.3.12	98	2				50				
		99	6					30			
55	2.3.13	100	3			70					
		101	4					30			
		102	5				50				
		103	6								0
56	2.3.14	104	1					30			
57	2.3.16	105	1								0
58	2.3.17	106	1								
		107	2								
59	2.3.18	108	1								
60	2.4.5	109	2					30			
		110	3						10		
		111	4					30			
61	2.4.6	112	5								0
62	2.4.7	113	1					30			
63	2.4.11	114	1				50				
64	2.5.2	115	2								
65	2.5.3	116	6					30			
		117	7				50				
66	2.5.4	118	1					30			
67	2.5.6	119	3								
68	2.5.7	120	2								0
69	2.5.9	121	1					30			
70	2.5.10	122	1					30			
ГУРАВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ ТЭНЦВЭРТ ХАРЬЦААГ ХАНГАХ ЗОРИЛТ											
71	3.2	123	1								0
		124	4								
72	3.3	125	2				50				
73	3.4	126	2					30			
		127	4				50				
74	3.5	128	2						10		
		129	10					30			

75	3.6	130	1					30			
		131	2					30			
76	3.7	132	1								0
77	3.9	133	1								0
78	3.14	134	2						10		
		135	8					30			
79	3.15	136	4					30			
		137	9					30			
80	3.16	138	4						10		
81	3.17	139	3					30			
		140	5						10		
82	3.18	141	2								0
		142	3								0
		143	4					30			
		144	5					30			
		145	6								0
		146	7					30			
83	3.19	147	2					30			
		148	3					30			
		149	4					30			
ДӨРӨВ. ЭРХ ЗҮЙТ ТӨРИЙГ ТӨЛӨВШҮҮЛЖ, ЗАСАГЛАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ИЛ ТОД, НЭЭЛТТЭЙ БОЛГОХ ЗОРИЛТ											
84	4.1.3	150	2					30			
		151	5					50			
85	4.2.10	152	3					50			
86	4.2.12	153	3								0
87	4.3.3	154	1					30			
88	4.5.4	155	3					30			
		156	4					30			
		157	5					30			
89	4.5.5	158	1					50			
		159	2					30			
		160	3						10		
		161	4					50			
		162	5					30			
		163	6					30			
90	4.5.6	164	6				50				
91	4.5.7	165	2						10		
		166	3					30			
		167	4						10		
92	4.5.8	168	1							0	
93	4.5.10	169	1					30			
ТАВ. ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН ЗОРИЛТ											
94	5.1.1	170	14					30			
95	5.1.4	171	6					50			
96	5.2.7	172	1					50			
97	5.3.4	173	2				70				

		174	3			70					
Дүн	100%	-									
	90%	3									
	70%	7									
	50%	33									
	30%	71									
	10%	22									
	Х/б	38									
	Дүн	35%									

АЙМГИЙН ЗДТГ-ЫН ДАРГА

Б.ЗАРХУМ